



UNITED NATIONS
MONGOLIA



2017-2019

Монгол улс дахь Нэгдсэн үндэстний байгууллагын ажлын үр дүнгийн

ТАЙЛАН



World Health Organization

IOM
UN MIGRATION

UN
DP

UNESCO

IAEA

FAO
FIAT PANIS

UN
environment
programme

WFP

unicef
for every child

UNFPA

UN HABITAT
FOR A BETTER URBAN FUTURE

UNIDO

2017-2021 НҮБ-ын

Хөгжлийн тусламжийн хүрээ

**МОНГОЛ УЛС ДАХЬ
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН
АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

2017-2019 он

(2017-2021) НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ

© НҮБ-ын СЗАА 2020

Бүх эрх хамгаалагдсан

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ		5
ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ		7
ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ НЭГ:	ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ	15
Зорилго 1.1	ТХЗ-той уялдуулсан хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, стратеги, төлөвлөгөөг боловсруулах; ингэхдээ ядуурлыг бууруулах, хүртээмжтэй өсөлт, эдийн засгийг төрөлжүүлэх, үндэсний болон орон нутгийн түвшинд эрсдэлийг даван туулахад бэлтгэлтэй байх нөхцөлийг бүрдүүлэх зэргийг тэргүүлэх чиглэлээ болгох	19
Зорилго 1.2	Зохистой ажлын байр, ур чадварыг бий болгох, цэвэр технологийг нэвтрүүлэх, байгаль орчны доройтол, байгаль орчны эрсдлээс урьдчилан сэргийлэх, ядуурлыг бууруулах зэрэгт чиглэсэн ногоон эдийн засгийн үндэсний стратегийг боловсруулж Монголын онцлогт тохирсон, ард иргэдийн оролцоонд тулгуурласан уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох, түүний нөлөөллийг бууруулах арга хандлагыг нэвтрүүлэх	24
Зорилго 1.3	Хөдөө орон нутгийн ядуу, эмзэг бүлгийн хүн амын амьжиргааг тэтгэдэг экосистемийн үйлчилгээг хамгаалах	28
Зорилго 1.4	Нутгийн иргэдийн гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг сайжруулах	31
ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ ХОЁР:	НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ, ЧАНАРТАЙ, ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БИЙ БОЛГОХ	34
Зорилго 2.1	Технологийн шийдэл, ус, ариун цэврийн байгууламжийн тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх замаар илүү таатай орчин бүрдсэн, мэдээлэл судалгаатай, нийгмийн ухамсараар дэмжигдсэн Ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сонгогдсон хотын захын хороолол болон сумдад сайжруулах	40
Зорилго 2.2	Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхийн тулд хот суурин, хотын захын хороолол болон хөдөө орон нутгийн ядуу, эмзэг хүн амын эрүүл мэндийг сайжруулах; эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээнд хүн бүр тэгш хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх; нотолгоонд суурилсан бодлого, шийдвэр гаргахад үндэснийхээ байгууллагуудтай хамтран ажиллахыг дэмжих	44
Зорилго 2.3	Илүү чанартай суурь боловсролыг дэмжиж, Хүүхдийг бага наснаас нь хөгжүүлэх, улмаар насан турш боловсрол эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хотын захын хорооллын сонгогдсон хэсгүүд, зарим сумдад хэрэгжүүлэх	47

Зорилго 2.4	Нийт хүн амыг, ялангуяа, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг ТҮЛХҮҮ хамруулсан үр ашигтай, үр нөлөөтэй нийгмийн хамгааллын тогтолцоог нэвтрүүлэх	51
Зорилго 2.5	Хүнс болон хоол тэжээлийн аюулгүй байдлыг бэхжүүлэх (эрүүл хүнс/ тэжээлийн орчинг бүрдүүлэх, хоол тэжээлийн дутлын эрсдэлийг эрс бууруулах, хүнс, хоол тэжээлийн тандан судалгаа, үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх)	54
ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ ГУРАВ:	ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИЖ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ	57
Зорилго 3.1	Хүний эрхийг хамгаалах, ялангуяа, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах зорилгоор олон улсын стандартад нийцүүлэн хууль эрх зүйн шинэчлэл хийж хяналтын тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэх замаар хууль эрх зүйн хамгааллын механизмыг сайжруулах	62
Зорилго 3.2	Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд, залуучуудын (34 хүртэлх насны) төлөөллийг нэмэгдүүлэх, тухайлбал, Монгол Улсын Их хурал, яамдын сайд, төрийн нарийн бичгийн дарга, аймгийн засаг дарга, иргэдийн хурлын төлөөлөгчдийн түвшинд	66
Зорилго 3.3	Залуучуудын холбоо, байгууллагуудыг бэхжүүлэх, тэдний санаа бодлоо эрх тэгш түншийн хувьд чөлөөтэй илэрхийлэхийг дэмжих	69
МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА		72
НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА		73
ХАВСРАЛТ: НИЙТ ТӨСВИЙН ХҮРЭЭ		75
ХОЛБОО БАРИХ ХҮМҮҮС		76

ӨМНӨХ ҮГ



ТАПАН МИШРА

Монгол Улс дахь
НҮБ-ын Суурин
Зохицуулагч

Монгол Улс дахь Нэгдсэн үндэстний байгууллагын системийн нийт 15 байгууллага нь Монгол Улсын Засгийн газартай харилцан зөвшилцөж 2017-2021 онд хэрэгжүүлэх НҮБ-ын Хөгжлийн туслалцааны хүрээг баталсан билээ. Энэ хүрээнд НҮБ-аас 2017-2019 онд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн тайлангаа үүгээр танилцуулж байгаадаа таатай байна. Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ) нь 1963 оноос Монгол Улсад үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тус улсын үндэстний хөгжлийн тэргүүлэх зорилгыг хэрэгжүүлэх хийгээд тогтвортой, эрх тэгш, хүртээмжтэй хөгжлийг хангахад чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааг дэмжин ажиллаж ирсэн.

Өнгөрөгч 2019 он бол НҮБ-ын хөгжлийн систем (НҮБХС)-ийн хувьд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан НҮБХС-ийн бодлогын шинэчлэлийн тухай 2018 оны Тавдугаар сарын 31-ний 72/279 тоот тогтоолын дагуу НҮБ-ын Суурин зохицуулагчийн эрх мэдэлжсэн, шударга, шинэчлэгдсэн албад байгуулагдаж үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн үетэй давхацсан онцгой жил байлаа. НҮБХС нь ийнхүү шинэчлэгдэн өөрчлөгдсөнөөр 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон эдийн засаг, нийгэм, байгаль орчны хөгжлийн уялдааг хангах чин зорилгоо үйл хэрэг болгохын тулд харилцан хүчээ нэгтгэх, үр дүнтэй арга хэмжээ авах нөхцөл бүрдэнэ.

Сүүлийн гурван жилийн хугацаанд Монгол Улсын нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд олон сорилт тулгарч байсан. Гэсэн хэдий ч Монгол Улсын Их хурлын сүүлийн гурван удаагийн бүрэлдэхүүн дамжин олон жил үргэлжилсэн мэтгэлцээний үр дүнд Монгол Улс нь 2019 оны Арваннэгдүгээр сард Үндсэн хуульдаа (1992) нэмэлт, өөрчлөлт оруулснаар улс төрийн тогтвортой байдлыг хангах, төрийн эрх мэдлийн хяналт, тэнцвэрийг оновчтой болгох, гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр томоохон алхам хийсэн. Эдгээр нэмэлт, өөрчлөлтийн дагуу цаашид олон арван хуульд өөрчлөлт орохоор байна.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар 2019 оны Тавдугаар сараас эхлэн тус улсын нийт хүн амын бараг тэн хагас нь амьдардаг нийслэл Улаанбаатар хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулах шийдвэртэй арга хэмжээ авсны үр дүнд нийслэл хотын агаарын болон хүрээлэн буй орчны бохирдлыг дорвитой хэмжээгээр бууруулж чадсан. Үүнийг уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх ажлын нэг хэсэг хэмээн миний бие сайшаан хүлээн авч байна.

Гэхдээ бид Тогтвортой хөгжлийн зорилгыг тууштай хэрэгжүүлэхийн тулд ирэх арван жилд ихээхэн хүчин чармайлт гаргах хэрэгтэй болж байна. Иймээс 2019 оны сүүлчээр НҮБ-аас Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх Арван жилийг дэлхий дахинаа зарлаж, ядуурлыг устгах, тэгш бус байдлыг арилгах, эмэгтэйчүүд, охидыг эрх мэдэлжүүлэх, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйлсэд хүн бүр оролцож хүчин зүтгэл гаргахыг уриалсан.

Монгол Улсын Засгийн газар нь ТХЗ-ыг хэрэгжүүлэхээр тууштай ажиллаж байгаа бөгөөд ТХЗ-той нийцүүлэн үндэстний хөгжлийн Алсын хараа 2050 баримт бичгийг саяхан баталсан билээ. Дэлхий дахинаа нүүрлээд байгаа цар тахлын хямралаас улбаалсан эдийн засаг, нийгмийн хүндхэн нөхцөлд НҮБ нь 75 жилийн ойтойгоо золгож байна. Хүн бүрийн төлөөх илүү сайн ирээдүйг бүтээх зорилгоор “НҮБ-75” хэлэлцүүлгийг дэлхий дахинаа өрнүүлж эхлээд байна.

Монгол Улсын Засгийн газраас 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх их амлалт, чин зорилгоо хэрэгжүүлэхэд нь Монгол Улс дахь НҮБ ямагт итгэлтэй түнш нь байх болно гэдэгт миний бие итгэлтэй байна. Монголын ард түмний төлөө Монгол Улсын Засгийн газар манлайлж хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг цогцлоох их үйлсийг дэмжин ажиллахдаа Монгол Улс дахь НҮБ-ын хамт олон бид ямагт баяртай байх болно.



■ ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Өнгөрсөн гурван жилийн хугацаанд НҮБ-ын системийн байгууллагууд нь стратеги бодлогын түвшинд хийгээд үндсэн нэгжийн түвшинд 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түүний хүрээнд Тогтвортой хөгжлийн 17 зорилгод хүрэхэд чиглэсэн Монгол Улсаас явуулж буй үйл ажиллагааг дэмжин ажилласан. Хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт төрөл бүрийн хууль тогтоомж, салбарын стратеги, мастер төлөвлөгөө, стандартыг шинэчлэн боловсруулж батлуулахад дэмжлэг үзүүлж ирлээ. Монгол Улс дахь НҮБ нь байгалийн нөөцийн тогтвортой менежмент, ногоон хөгжлийг дэмжих, агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх зэрэг асуудлыг шийдвэрлэх замаар байгаль орчныг хамгаалах; эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хүний эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдал, ус, ариун цэврийн байгууламж, хүнс, хоол тэжээлийн хангамж, гамшгийн эрсдэлийг арилгах зэрэг олон асуудлыг шийдвэрлэх замаар хүмүүсийн сайн сайхан аж байдлыг хангах, улмаар орон нутгийн засаг захиргаад, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэгт гол үйл ажиллагаагаа хандуулж байна.

Тайлангийн хугацаанд НҮБ-ын системийн байгууллагууд нийтдээ 113.65 сая ам.долларын хөрөнгийн санхүүжилт босгосон бөгөөд үүнээс 66.49 сая ам.долларын хөрөнгийг түншлэгч 56 байгууллагуудтай (IP) хамтран 19 аймаг, нийслэл хотод хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн 109 төрлийн үйл ажиллагаанд зарцуулсан байна. Эдгээр үйл ажиллагааны 83 нь улсын хэмжээнд тодорхой үр нөлөө үзүүлсэн. Энэ бүх үйл ажиллагаа нь Тогтвортой хөгжлийн нийт 16 зорилгыг хэрэгжүүлэх үйлсэд түлхэц үзүүлсэн бөгөөд нийт хөрөнгийн зарцуулалтын 87 хувь буюу 57.9 сая ам.долларын хөрөнгийг ТХЗ 3 – Эрүүл мэндийг дэмжих (22 хувь), ТХЗ 5 – Жендэрийн эрх тэгш байдлыг хангах (10 хувь), ТХЗ 2 – Өлсгөлөнг эцэслэх (10 хувь), ТХЗ 15 – Хуурай газрын эко системийг хамгаалах (9 хувь), ТХЗ 16 – Энхтайван, Шударга ёсыг цогцлоох (8 хувь), ТХЗ 17 – Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх (8 хувь), ТХЗ 13 – Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах (6 хувь), ТХЗ 12 – Хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих (5 хувь), ТХЗ 4 – Боловсрол (5 хувь), ТХЗ 8 – Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих (5 хувь) зэрэг Тогтвортой хөгжлийн арван зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулсан.

Монгол Улсын Засгийн газар нь НҮБ-тай нягт хамтран ажиллаж ирсний зэрэгцээ зарим төсөл хөтөлбөрт хамтран санхүүжүүлэгч болж ажиллах нь улам бүр нэмэгдэж байна. Сүүлийн гурван жилийн хугацаанд л гэхэд Монгол Улсын Засгийн газраас 3.1 сая орчим ам.долларын хөрөнгийг хөтөлбөрийн үйл ажиллагааны санхүүжилтэд оруулсан байна. Хамтын ажиллагааны олон сайхан амжилтын нэг жишээ бол Монгол Улсын Засгийн газраас үзүүлсэн дэмжлэг, хамтарсан санхүүжилтийн үр дүнд Далайд гарцгүй хөгжиж буй орнууд (ДГХБО-LLDC)-ын Олон улсын судалгааны төв (ОУСТ-ИТТ)-ийг Монгол Улсад 2018 онд байгуулсан явдал юм.

Стратегийн төлөвлөгөө, бодлого боловсруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх

НҮБ нь олон талын оролцоог дэмжсэн платформ, яриа хэлэлцүүлгээр дамжуулан ТХЗ-ын суурь түвшин, зорилтуудыг тодорхойлох, Монгол Улсын хөгжлийн болоод ТХЗ-ын хүрээнд хүрэх зорилтуудын хэрэгжилтэд тогтмол хяналт шинжилгээ хийхэд тусламж дэмжлэг үзүүлж байна.

Үүнтэй холбогдуулан НҮБ нь нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, шийдвэр гаргах болон бусад олон төрлийн хэрэглээнд шаардагдах нарийвчилсан тоо мэдээллийг бий болгох чиглэлээр Үндэстний статистикийн хороонд техникийн туслалцаа үзүүлсэн. НҮБ нь үндэстний чадавхыг бэхжүүлэх замаар ТХЗ-ын санхүүжилтийг сайжруулах, ялангуяа хүүхдийн асуудалд чиглэсэн санхүүжилт, Эрүүл мэнд, Байгаль орчны салбарын ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажиллаж байна. Энэхүү хамтын хүчин чармайлтын үр дүнд Монгол Улсын Засгийн газраас Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэстний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл, бичил тэжээлийн чиглэлээрх 2020 оны хуваарилагдсан төсөв дээр 300 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хуваарилаад байна.

Байгаль орчныг хамгаалах

НҮБ-ын системийн байгууллагууд нь Монгол Улсын Засгийн газартай нэг баг болон газрын нөөцийг зохистой ашиглахад чиглэсэн байгаль орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн үр нөлөөг сайжруулах олон төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Тухайлбал, бэлчээр сэлгэлт, усны эх үүсвэрийн хамгаалалт, газар тариалангийн талбайн нөхөн сэргээлт, ойн үржүүлэг, ойн тогтвортой менежмент зэрэг олон санал санаачилгыг идэвхтэй өрнүүлж байна. Хамтын хүчин чармайлтын үр дүнд 5.7 сая га газрыг улсын болон орон нутгийн хамгаалалтад авлаа.

НҮБ-ын системийн байгууллагууд нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоог бэхжүүлэх зорилгоор нарны эрчим хүч буюу сэргээгдэх эрчим хүчийг гүний худагт ашиглах уур амьсгалын ухаалаг аргыг турших, мал аж ахуйн арга техник болон малын тоо толгойноос илүүтэй чанарт нь анхаарч мал сүргийн зохистой бүтцийг бий болгож бэлчээрийн менежментийг сайжруулах зэрэгт түлхүү анхаарч ажиллаж байна.

Хот суурингийн агаарын бохирдолтой холбоотой олон асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн агаарын бохирдлыг бууруулах талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулахад шаардагдах мэдээлэл нотолгоог бий болгох, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн шинэлэг шийдлийг турших зэрэгт НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлж байна. НҮБ-ын дэмжлэгтэйгээр эрчим хүч хэмнэлтийг дэмжих туршилтын төслүүдийг хэрэгжүүлснээр зөвхөн 2019 онд гэхэд хүлэмжийн хийн шууд ялгарлыг 5,220 тонн CO₂-экв хүртэл бууруулсан байна. Эрчим хүчний зохистой хэрэглээ, хэмнэлтийг дэмжих эдгээр төсөл хөтөлбөрийн үр дүнд үндэстний хэмжээний мэргэжлийн чадавх сайжирч, барилгын эрчим хүч хэмнэлтийн хэм хэмжээ, норм, стандартыг шинэчилсэн. Нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулахын тулд үйлдвэрлэлийн илүүдэл хийг боловсруулах цахилгаан дамжуулгын хүчин чадлыг (Electron Beam Capacities) ашиглах шийдлийг туршихад НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлсэн болно.

Түүнчлэн НҮБ-ын дэмжлэгтэйгээр хэд хэдэн аймаг орон нутгийн засаг захиргаад орон нутгийнхаа хөгжлийн төлөвлөгөөг ногоон хөгжлийн зарчим, ТХЗ-той уялдуулан боловсруулж орон нутгийнхаа хүн амын амьжиргаа, тогтвортой байдлыг хангахаар ажиллаж байна.

Хүүхэд, эмэгтэйчүүд, охид, залуучууд, эмзэг бүлгийн хүн амын аж байдлыг сайжруулах

НҮБ-аас хүн амын эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаандаа Монгол Улсын хүн амын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмнэлэг эмчилгээний чадавхыг өргөжүүлэн тэлэх, Эх, нярай, хүүхдийн эрүүл мэндийн (MNCH) нэгдсэн тусламж үйлчилгээний

хүртээмжийг нэмэгдүүлэх, хөдөлгөөнт-эрүүл мэндийн (m-health) тусламж үйлчилгээ, телемедицин зэрэг тусламж үйлчилгээний шинэлэг хэлбэрийг хөгжүүлэх, оношилгооны нарийвчлал, чанарыг сайжруулахын тулд цөмийн анагаах ухааны арга техникийн ашиглалтын чанарыг сайжруулах зэрэгт голлон анхаарч ажиллаж байна.

Ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, үйлчилгээний хууль эрх зүйн орчныг бүрдүүлж санхүүжилт, хөндлөнгийн хяналтын механизмыг бэхжүүлэх замаар Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндэсний чадавхыг сайжруулахад нь Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас дэмжлэг үзүүлж байна. Түүнчлэн ундны усны тарифыг тогтоох аргачлалыг шинээр нэвтрүүлсэн нь гэр хорооллын иргэдийн хэрэглээний усны үнийг бууруулж, ундны усыг хямд үнээр ашиглах боломжийг бүрдүүллээ. Түргэн үйлчилгээний ухаалаг системд шилжүүлсэн ус түгээх цэгүүдийг хоёр аймагт ажиллуулж туршсан нь ундны усны үйлчилгээний хүртээмж тэлэгдэж, ашиглалт, засвар үйлчилгээний өртөг буурч байгааг нотолж өгсөн. Үүний үр дүнд нэг аймгийн (Говь-Алтай) захиргаа аймгийн төвдөө нэмж 20 гаруй Түргэн үйлчилгээний ухаалаг системд шилжүүлсэн ус түгээх цэгүүдийг байгуулахаар санхүүжилтийг нь баталгаажуулсан. Ингэснээр Алтай хотын 16000 иргэн тогтмол ажиллагаатай 21 Түргэн үйлчилгээний ухаалаг системд шилжүүлсэн ус түгээх цэгээс хоногийн 24 цагийн туршид ундны усаар хангагдах боломж бүрдэж байна.

НҮБ-аас үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, газар тариалан эрхлэгчдийн орлогыг өсгөх, хөдөлмөр эрхлэлт, хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэх зэрэг боломж нөхцлийг бүрдүүлэхийн зэрэгцээ байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж хүнсний аюулгүй байдал, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр Монгол Улсын засгийн газарт тусламж дэмжлэг үзүүлж байна. НҮБ-ын тусламжтайгаар Монгол Улсын Анагаахын шинжлэх ухааны их сургууль нь тэжээхүйн ухаан, хоол судлаачийн бакалаврын зэрэг олгох сургалтын анхны хөтөлбөрийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Тав хүртэлх насны 35,300 гаруй хүүхэд хоол тэжээлийн нэгдсэн багц үйлчилгээнд хамрагдлаа. Түүнчлэн НҮБ-аас үндэсний үйлдвэрлэлийн болон импортын бүтээгдэхүүнд малын эмийн үлдэгдэл бодис агуулагдаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийхэд тусламж дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд цаашид Европын холбооны экспортын шаардлагыг хангах хүчин чадлыг өргөжүүлэхээр төлөвлөж байна. Үүний үр дүнд түүхий эд, бүтээгдэхүүнийг лабораторийн магадлан итгэмжлэлд хамруулах хүрээ тэлэгдэж нийтдээ 2561 гаруй экспорт, импортын түүхий эд, бүтээгдэхүүний дээжээс авсан сорьцод антибиотикийн агууламж, пестицид, меламинагийн бохирдлын шинжилгээ хийжээ.

Боловсролын салбарт, НҮБ нь бага насны хүүхдийн боловсрол, дээд боловсрол, хүн амын насан туршийн болон техник мэргэжлийн боловсролын чиглэлээр Засгийн газраас явуулж байгаа үйл ажиллагааг дэмжин ажиллаж байгаагийн зэрэгцээ мэдлэг боловсролыг хөхиүлэн дэмжих, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, институцийн хийгээд хүний нөөцийн түвшинд чадавхыг хөгжүүлэх замаар Чанартай боловсролыг дэмжих ТХЗ-4-ийг нутагшуулан хэрэгжүүлж байна. НҮБ-аас явуулж буй өргөн хүрээний нөлөөлөл сурталчилгааны ажлын тусламжтайгаар эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын 4-12-р ангийн сургалтын хөтөлбөрт албан ёсны хөтөлбөр болгон тусгалаа. Үүний үр дүнд улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 4-12 дугаар ангийн нийт 377,932 сурагч тус сургалтын хөтөлбөрт хамрагдсан болно. Бүр цаашилбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших таатай орчинг ердийн сургуулиудад бий болгож боловсролын үйлчилгээний тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхэд НҮБ-аас тууштай дэмжлэг үзүүлж байна. Бага насны хүүхдийн боловсролын төвүүдэд хүүхэд сурч

боловсрох эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэхэд тулгарч буй сорилт бэрхшээлийг арилгах зорилгоор дотоод орчны агаарын чанарыг сайжруулах, зорилтот бүс нутгууд дахь Ундны ус, ариун цэврийн байгууламжийг сайжруулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд тодорхой алхамуудыг хийлээ.

Нийгмийн хамгааллын чиглэлээр, Монгол Улс дахь НҮБ нь нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэхийн зэрэгцээ нийгмийн хамгааллын бодлогыг хариуцсан үндэстний болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын чадавх, мэдлэг мэдээллийг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалсан гамшгийн урт хугацаанд үргэлжлэх сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор хахир хүйтэн өвлийг даван туулахад нь айл өрхүүдэд туслах үүднээс НҮБ-ын гамшгийн эсрэг тэмцэх хөтөлбөрөөс хүүхдийн мөнгөний хөтөлбөрт нэмэлт мөнгөн тусламж үзүүлсэн болно. Бага насны хүүхдэд зориулсан урьдчилсан мөнгөн тусламжийг Завхан аймгийн 4 сумын 0-5 насны нийт 2,729 хүүхдэд үзүүлсэн. Үүний зэрэгцээ, НҮБ-ын дэмжлэгтэйгээр 2017 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж эхэлсний үр дүнд орон нутгуудад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 30 гаруй Зохицуулах зөвлөл, олон талын төлөөлөл орсон 609 баг, Нэг цэгийн үйлчилгээний төвүүд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах байрууд байгуулагдсан. Хүүхдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үндэстний хэмжээний хамгааллын механизмыг бэхжүүлэхийн зэрэгцээ хүн худалдаалах, аливаа ялгаварлан гадуурхалт, үзэн ядалтыг өдөөх, бэлгийн чиг хандлага, хүйсэд суурилсан хүчирхийлэл зэрэгтэй тэмцэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас явуулж байгаа үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлж хамтран ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлж хүн амын амьжиргааг сайжруулах

НҮБ-ын системийн байгууллагууд нь мал аж ахуй, мах, махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, хүнсний ногоо, нэхмэл эдлэл, ноолуур зэрэг салбарын өртөгийн сүлжээг хөгжүүлэх замаар Монгол Улсын хот суурингийн зах орчмын болон хөдөө орон нутагт ажлын байр бий болгох чиглэлээр ажиллаж байна. Үүний үр дүнд мах боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадал 30 хувиар нэмэгдэж, 11000 гаруй хүний орлого өсч, 180,000 орчим хэрэглэгчдийн чанартай мах махан бүтээгдэхүүний хүртээмж сайжирсан байна. Түүнчлэн 160 гаруй газар тариалан эрхлэгчид зохистой хөдөлмөр эрхэлж, 500 гаруй ногоочдын орлого сүүлийн гурван жилд 30 хувиар нэмэгджээ. НҮБ нь ОУХБ-ын конвенц, зөвлөмжийг хэрэгжүүлэх гурван талт зөвшилцлийн механизмыг хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, ажил олгогчид, ажилчдын байгууллагуудад техникийн туслалцаа үзүүлж дэмжин ажиллаж байна.

Эрсдэлийг сөрөх нийгмийн бүлгүүдийн чадвар

НҮБ-ын системийн байгууллагууд нь хахир хүйтэн зуд турхан болон хот суурин газруудад тохиох үер усны гамшгаас үүдэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ болон хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Цаашид тэгш бус байдлыг бууруулах зорилго агуулан шилжин суурьшигчдыг сайн дурын үндсэн дээр уугуул нутагтаа буцаж шилжих болон шинэ тутам газарт нь нийгэмшүүлэх зэрэг ажлыг зохицуулж шилжилт хөдөлгөөнийг удирдах чиглэлээр Засгийн газарт НҮБ-аас дэмжлэг туслалцаа үзүүлээ.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр нийслэлийн засаг захиргаанаас Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд ундны ус, ариун цэвэр, ариутгах татуургын байгууламжийн төлөвлөгөөт дэд бүтцийг байгуулж байна.

Орон нутгийн засаг захиргаа

Монгол Улсад мэргэжлийн бөгөөд иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаагаараа дамжуулан НҮБ нь төрийн албаны хариуцлагыг сайжруулах, ядуу болон эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах зорилгоор хэд хэдэн чухал алхамыг хийсэн. Төрийн албан хаагчид мэргэжлийн түвшний, иргэн төвтэй, чанартай үйлчилгээг хүний эрхийг хүндэтгэж үндэсний болоод орон нутгийн аль ч түвшинд хүргэх чадавхыг хөгжүүлэхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлж байна. Түүнчлэн НҮБ нь орон нутгийн нийт засаг захиргааны чадавхыг бэхжүүлэх зорилгоор тэдний өвөрмөц онцлог хэрэгцээнд нийцүүлэн үйл ажиллагаагаа тодорхойлон хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2000 гаруй эмэгтэй төлөөлөгчдөд зориулж улс төрийн шийдвэр гаргах үйл хэрэгт тэднийг илүү үр дүнтэй оролцох чадавхыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулсан. Үүний зэрэгцээ НҮБ-аас Улсын их хурал дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн квот тогтоох талаарх байр сууриа тууштай илэрхийлж байсны үр дүнд квотыг хүчингүй болгож болзошгүй байсан эрсдэлээс сэргийлж улс төрийн нам, эвслээс сонгуульд нэр дэвшигчдийн жендэрийн квотыг 20 хувь болгож Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад баталгаажуулахад тодорхой хувь нэмэр оруулсан.


Залуучуудын хөгжил

НҮБ-ын дэмжлэгтэйгээр амьдрах ухааныг хөгжүүлэх, бэлгийн боловсрол олгох, хөдөлмөрлөх эрх, өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэнд зэрэг олон асуудлыг хамруулж залуучуудад олон чиглэлийн ур чадвар олгож эрх мэдэлжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн Залуучуудын хөгжлийн 30 төвийг үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулсан. Орон нутгийн түвшинд залуучуудын боловсролыг дэмжих үйл ажиллагаанд ч НҮБ-аас дэмжлэг үзүүлж байна.


Монгол Улс дахь НҮБ нь хөтөлбөрийнхөө цар хүрээг нэмэгдүүлэхийн хэрээр үйл ажиллагааныхаа зардлыг хэмнэхэд анхаарч НҮБ-ын нийтлэг бизнесийн үйл ажиллагаа, үйлчилгээнийхээ үр ашгийг ахисан түвшинд гаргах үйлсээ үргэлжлүүлэн ажиллаж байна.

БОСГОСОН ХӨРӨНГӨ:

НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭРЭЭР 2017-2019




НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛЭЭР 2017-2019




ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ:

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛЭЭР

- Үр дүн 3: Олон нийтийн дуу хоолой, тайлагнах...
- Үр дүн 2: Нийгмийн хамгааллыг сайжруулах...
- Үр дүн 1: Хүртээмжтэй өсөлт, байгалийн нөөцийн ...




НҮБ-ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТ ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ




ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЭХНИЙ 10 ЗОРИЛТ 2017-2019

ЗАРЦУУЛАЛТ



ХАМГИЙН ӨНДӨР ЗАРЦУУЛАЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ 9 БАЙГУУЛЛАГА 2017-2019

ЗАРЦУУЛАЛТ



ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ НЭГ:



ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ




ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ:

2021 ОН ГЭХЭД ЯДУУ БОЛОН ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮН АМЫН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАР НЭМЭГДЭЖ, ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, ЭРҮҮЛ ЭКОЛОГИЙН ТОГТОЛЦООНЫ ҮР ШИМИЙГ ЭДЭЛНЭ

НҮБ нь Монгол Улсын хөгжлийн бодлогын хүрээг тодорхойлох, институцийн тогтолцоог хөгжүүлэх, хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг хангах үндэсний чадавхыг хөгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлсээр ирсэн билээ. НҮБ-ын системийн 12 байгууллага хамтран тайлангийн хугацаанд нийтдээ 61.25 сая ам.долларын хөрөнгийн санхүүжилт босгосноос 32.57 сая ам.долларын хөрөнгийг түншлэгч 30 байгууллагуудтай хамтран 18 аймаг, нийслэл Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа 55 төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд зарцуулсан байна. Нийт зарцуулалтыг Тогтвортой хөгжлийн 14 зорилгыг хэрэгжүүлэхэд буюу ядуурлыг устгах, өлсгөлөнг эцэслэх, эрүүл мэндийг дэмжих, аж байдлыг сайжруулах, жендерийн эрх тэгш байдлыг хангах, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах, сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн өсөлтийг дэмжих, үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, тэгш бус байдлыг бууруулах, ээлтэй хот, хариуцлагатай хэрэглээг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, хуурай газрын экосистемийг хамгаалах, хөгжлийн төлөөх түншлэлийг хөгжүүлэх зэрэгт чиглэсэн үйл ажиллагааг дэмжихэд зарцуулаа.

Нийт 18 аймаг болон Улаанбаатар хотод дээрх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.



Хөгжлийн стратеги, төсвийн төлөвлөгөөг Тогтвортой хөгжлийн зорилготой нийцүүлэх

Хөгжлийн бодлогын оновчтой тогтолцоог хөгжүүлэхийг дэмжиж, НҮБ нь ядуурлыг бууруулах, жендэрийн мэдрэмжтэй хөгжлийн стратегид суурилсан харилцан уялдаа бүхий хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлэх замаар Монгол Улсын Засгийн газарт үзүүлэх тусламжаа үргэлжлүүлж байна. Монгол Улс хөгжлийн тэргүүлэх чиглэлээ ТХЗ-ыг хэрэгжүүлэх зорилттой уялдуулан улсын төсөвтөө тусгаж байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор НҮБ-ын зүгээс Монгол Улсын Сангийн яамны дараалсан хоёр жилийн улсын төсөв боловсруулах ажилд дэмжлэг үзүүлж ажилласан. Ингэхдээ 2018 оноос Эрүүл мэндийн яамны төсвийн багцыг боловсруулахаас эхэлж улмаар өргөжүүлэн тэлж 2019 оноос Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсвийн багцыг боловсруулах ажилд дэмжлэг үзүүллээ. Үүний үр дүнд ТХЗ-ын зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт санхүүжилтийг тооцоолсны үндсэн дээр эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд хуваарилсан улсын төсвийг 6.9 тэрбум төгрөгөөр (~2.6 сая ам.доллар) нэмэгдүүлж, экосистемийг хамгаалах, тэр тусмаа тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийг хамгаалах, хөрсний доройтол/цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, 2020 онд усны нөөцийг сайжруулах чиглэлийн төсвийн санхүүжилтийг 5.1 тэрбум төгрөгөөр (~1.9 сая доллар) нэмэгдүүлэх шаардлагатай байгааг нотолж өгсөн.

Энэхүү туршилтын төслийг хэрэгжүүлснээр Монгол Улсын Засгийн газар улсын төсвийг боловсруулахдаа ТХЗ-той уялдуулдаг байх зарчмыг баталгаажуулж өгсөн. Үүний үр дүнд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө ТХЗ-той уялдуулсан эсэхийг хянах үр дүнгийн 11 үзүүлэлтийг Засгийн газраас 2019 онд шинээр баталсан. Түүнчлэн ТХЗ-ын шинэчлэгдсэн ойлголт тодорхойлолтын дагуу ТХЗ-ын 31 шалгуур үзүүлэлтийг жендэр, нийгэм-эдийн засгийн төлөв байдал, газарзүйн байршил болон бусад олон шинж байдлаар нь нарийвчилсан задаргаатайгаар тооцох, ТХЗ-ын зорилтуудыг тодорхойлох, улмаар хэрэгжилтэд нь хяналт шинжилгээ хийх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр үндэсний статистикийн чадавхыг сайжруулахад НҮБ-ын системийн байгууллагууд хамтран дэмжлэг үзүүлж байна. ТХЗ-ыг хэрэгжүүлэх орон нутгийн болон үндэсний чадавхыг бэхжүүлснээр ТХЗ-ыг гамшгийн эрсдэлийг сөрөх чадвартай хийгээд зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх жишиг болох, харилцан суралцах платформыг бий болгоно. Түүнчлэн үндэсний хөгжлийн богино, дунд хугацааны төлөвлөгөө, төсвийг урт хугацааны хөгжлийн бодлого, ТХЗ-ын бодлоготой уялдуулах зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлсэн. Энэ үнэлгээний үр дүнд үндэслэн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж Засгийн газарт өргөн барьсан.

Газрын тогтвортой менежмент

НҮБ нь Монгол Улсын баруун бүсэд газрын тогтвортой менежментийн нэгдсэн арга туршлагыг нэвтрүүлэх замаар газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх механизмыг дэмжих зорилго агуулан орон нутгийн засаг захиргаад, хувийн хэвшил, орон нутгийн иргэдтэй хамтран ажиллалаа. Нийт 5.7 сая га (Их Британи Улсын нийт газар нутагтай тэнцэх хэмжээний) газар нутгийг улсын болон орон нутгийн хамгаалалтад авч, уул уурхайн олборлолт явуулахаас хамгаалж, байгаль орчны үнэт зүйлсийг зүй зохистойгоор ашиглаж байна. Түүнчлэн эко-бүсийн үнэлгээгээр баруун таван аймгийн 22.8 сая га газар нутгийг орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд оруулж өгсөн нь биологийн олон янз байдал, газрын хэвлийн үнэт зүйлс, экосистемийн үйлчилгээг хамгаалахад чухал ач холбогдолтой юм. Хөндлөнгийн үнэлгээний багийн дүгнэлтээр бэлчээрийг сайжруулах (78,600 га газар сэлгэн бэлчээрлүүлэх), усны эх үүсвэрийг хамгаалах, тариалангийн талбайг нөхөн сэргээх болон ойн үржүүлэг зэрэг газрын тогтвортой менежментийн арга туршлагыг НҮБ-ын тусламжтайгаар хэрэгжүүлсний үр дүнд газар ашиглалтын төлбөр, газрын тогтвортой менежментийн талаарх нутгийн иргэдийн ойлголтын түвшин 50 орчим хувиар нэмэгдсэн байна.

Байгалийн нөөцийг зохистой ашиглах


НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (НҮБУАӨСК/UNFCCC) түүний Парисын хэлэлцээрт заасан Ил тод байдлын тогтолцооны хүрээ (ИТБТХ/ETF), Хөдөө аж ахуй, ой, бусад салбарын газар ашиглалтаас (ХААОГА/AFOLU) ялгарах хүлэмжийн хийн тооллого, Монгол Улсын оруулах Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн (ҮТХН/NDC) хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд шаардагдах мэдээлэл зэрэг төрөл бүрийн тайлан илтгэл бэлтгэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлээ.

2019 оны турш, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөө боловсруулах Үндэсний чадавх бэхжүүлэх төслийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг Монгол Улсын хөгжлийн стратегид тусгахад зориулан бодлогын товчоон боловсруулах замаар салбаруудын бодлогод үнэлгээ хийж Монгол Улсын хүртээмжтэй өсөлт, байгалийн баялгийн зохистой менежментийг дэмжин ажилласны зэрэгцээ Монгол Улсын ҮТХН-ийн баримт бичгийн дасан зохицох хэмээх хэсэгт үнэлгээний үр дүнг тусгаж 2019 оны 11-р сард батлуулсан. НҮБУАӨСК-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ҮТХН баримт бичгийг бэлтгэж тайлагнах ажилд НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлсэн бөгөөд уг тайланд агаарын бохирдлыг бууруулж, байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22,7 хувь хүргэж бууруулах том зорилт дэвшүүлсэн. Энэ нь ямар ч арга хэмжээ авахгүй байх тохиолдолд 14% байгаа болно.


Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах стратеги, хүлэмжийн хийн тооллого, хүлэмжийн хийн хяналт шинжилгээ, тайлагналт, баталгаажуулалтын (ХШТБ/MRV) систем зэргийг хэрэгжүүлснээр Монгол Улс нь үр дүнд суурилсан төлбөрийн систем тогтооход нэг алхам ойртсон. Энэ чиглэлээр шинэлэг технологийг ашигласан хэд хэдэн туршилтын төслийг хэрэгжүүлснээр эрчим хүчний үр ашгийг дээшлүүлсэн. Үүний үр дүнд 2019 онд нийтдээ 5,220 орчим тонн CO₂-экв хүлэмжийн хийг бууруулж, ойролцоогоор 32,000 амдолларын өртөг бүхий эрчим хүчийг хэмнэсэн байна. Энэхүү төслийг хэрэгжүүлсний үр дүнд, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх үндэсний мэргэжлийн чадавхыг бэхжүүлж 25 бие даасан эрчим хүчний аудитор, менежерийн эрхийг баталгаажуулж, барилгын норм, дүрмийг шинэчилж (BNbD 23-02-09) барилгын дулаан хадгалалтын норм стандартыг сайтар мөрдөх боломж бүрдсэн.

ЗОРИЛГО 1:


НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, ХАМГИЙН ӨНДӨР 16 САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



САНХҮҮЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ЗОРИЛГООР 2017-2019



ЗОРИЛГО 1.1:



ТХЗ-ТОЙ УЯЛДУУЛСАН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, АЛСЫН ХАРАА, СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ; ИНГЭХДЭЭ ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ, ҮНДЭСНИЙ БОЛОН ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ЭРСДЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХАД БЭЛТГЭЛТЭЙ БАЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗЭРГИЙГ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭ БОЛГОХ

ТХЗ-ын платформ, мэдээллийн систем

Байгаль орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол нь Монгол Улсын нийт хүн амын эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.



Ил тод, оролцоог дэмжсэн арга хэмжээг хэрэгжүүлэх замаар НҮБ нь Монгол Улсын Засгийн газарт ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон талын оролцоог хангасан платформыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ирсэн. Салбарын яамд, хэрэгжүүлэгч агентлагууд, эрдэм шинжилгээний байгууллагууд, статистикийн албад, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын оролцоотойгоор үндэснийхээ

ТХЗ-ын суурь түвшин, зорилтыг тодорхойлоход Үндэсний хөгжлийн газарт дэмжлэг үзүүлсэн. Ингэснээр олон талт харилцан яриа хэлэлцүүлгийг өрнүүлэх, оролцогч талуудын дунд зөвшилцлийг бий болгох, хөгжлийн өргөн хүрээний асуудлаар нэгдсэн ойлголтод хүрэх үндэс суурийг бүрдүүлэхэд хувь нэмэр орууллаа.

Энэ ажлыг хийхдээ “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримталж хөгжлийн үр шимээс хоцрогдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийг тодорхойлсон үндэсний хэмжээний ТХЗ-ын хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээний мэдээллийг ашигласан. НҮБ-ын техникийн туслалцаатайгаар чадавх бэхжүүлэх зорилтот арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд хүүхдэд ээлтэй төсөв боловсруулах талаарх орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын мэдлэг чадавх сайжирч хүүхдийн асуудалд чиглэсэн төсөв санхүүгийн хуваарилалт нэмэгдсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төслүүдийн зарцуулалт 7-16 хувиар (2018 оноос) өссөнөөр 2019 онд орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог хангах орон нутгийн засаг захиргааны үүрэг, хариуцлага нэмэгдэж байгааг тодорхойлж болох юм. Түүнчлэн, Глобал компакт, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс баталсан “Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмууд” зэрэг олон улсын стандарт хэм хэмжээнд нийцсэн бизнесийн үйл ажиллагаагаар дамжуулан хүний эрхийн чиг баримжаатай, хүүхдэд илүү ээлтэй бизнес эрхлэлт бий болж байна. Үндэсний Статистикийн



газар (ҮСХ), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) болон бусад төрийн байгууллагуудаас хийж байгаа Монгол Улсын хөгжлийн болоод ТХЗ-ын зорилтуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээний ажлыг дэмжин НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлж байна. 2019 онд олон хэмжээст ядуурлын түвшинг тодорхойлох аргачлалыг боловсруулсны зэрэгцээ дүн шинжилгээ хийх мэргэжлийн ур чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн. ҮСХ-ны Статистикийн зөвлөлөөс ядуурлын индексийг 2020 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг үндэслэн тооцох аргачлалыг баталж, мэдээллийг цуглуулахдаа хүн амын бүлгүүд, тэр дундаа хамгийн эмзэг хэсгийнхэн, тэр бүр судалгаанд хамрагдаад байдаггүй хүн амын бүлгүүдийг олж хамруулах нөхцөлийг бүрдүүлэх, улмаар хүүхдийн ядуурлын түвшинг тодорхойлох зэргээр олон талын дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх шийдвэр гаргасан болно. Түүнчлэн НҮБ-ын системийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр Үндэстний статистикийн хорооноос удирдан явуулдаг Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгааг (Multiple Indicator Cluster Survey) 2019 онд хийх боломжийг бүрдүүлж, нийгэм, эдийн засгийн олон шинжээр нь янз бүрийн түвшинд нарийвчилсан задаргаатай мэдээлэл гаргах бас нэг чухал санг бий болгоод байна.

Олон улсын стандартад нийцсэн хөгжлийн стратеги

НҮБ-аас ТХЗ-ын хэрэгжилтийн үзүүлэлтүүдийг хянах систем (dashboard), Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явцад хяналт шинжилгээ хийх үндэстний чадавхыг сайжруулах чиглэлээр Монгол Улсын засгийн газарт дэмжлэг үзүүлж байна. Үүний зэрэгцээ ҮСХ нь “Зохистой хөдөлмөрийг дэмжиж 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь: ТХЗ-ын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, улс орны төлөв байдал” хэмээх тайланг боловсруулж, Монгол Улсын зохистой хөдөлмөрийн үзүүлэлтүүдэд нарийвчилсан дүн шинжилгээ хийсэн. Ийнхүү НҮБ-ын дэмжлэгтэйгээр ҮСХ нь албан болон албан бус эдийн засгийн аль ч салбарт албан бус хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн талаарх тоо мэдээллийг олон улсын аргачлалын дагуу цуглуулж оновчтой тооцох боломж олгох Ажиллах хүчний судалгааг бие даан хийх чадвартай болсон. Албан бус эдийн засагт хөдөлмөр эрхлэгчдийн эрхийг хамгаалах, маргаан шийдвэрлэх механизмыг нэвтрүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчид болон бусад олон ажиллагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилго агуулан албан бус салбараас албан ёсны эдийн засагт шилжих шилжилтийг тууштай дэмжих үүднээс Засгийн газар, ажил олгогчид болон ажилчдын байгууллагуудад НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлж байна. Хөдөлмөрийн ертөнц улам бүр стандарт бус хэлбэрүүдээр баяжин өөрчлөгдөж байна. Үүнтэй холбоотойгоор тулгарч буй сорилт бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор НҮБ-аас ажил, хөдөлмөр эрхлэлтийн цаашдын хандлагын талаар цуврал хэлэлцүүлгүүдийг эхлүүлээд байна.

Нотолгоонд суурилсан бодлогын хөгжлийг дэмжих үүднээс төрийн болон төрийн бус байгууллагууд үр дүнтэй бодлого, стратегиа тодорхойлохоор хамтран ажиллаж байна. Тухайлбал, Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай НҮБ-ын БШУСБ (UNESCO)-ын 2005 оны конвенцийн дагуу эрх чөлөөний суурь зарчмуудыг хамгаалан дэмжих зорилгоор олон талын төлөөллийг хамруулсан үндэстний багийг бүрдүүлж Монгол Улс дахь Конвенцийн хэрэгжилт, цаашид авах бодлогын арга хэмжээний талаарх үндэстний тайланг (Mongolia's Quadrennial Periodic Report) боловсруулахад НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (БСШУЯ)-наас Шинжлэх ухаан,


технологийн мастер төлөвлөгөө (2007-2020 он)-ний хэрэгжилтэд үнэлгээ хийх болон салбарын яамд, судалгаа шинжилгээний байгууллагууд, Үндэсний хөгжлийн газар, Шинжлэх ухаан, технологийн сангууд, хувийн хэвшлийнхэн зэрэг өргөн хүрээний төлөөллийг оролцуулан 2020 оноос цааш шинээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулахад НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлээ.

Зохистой хөдөлмөр, өртгийн сүлжээ

Монгол Улсын хот суурин орчмын бүсүүдэд болон хөдөө орон нутагт ажлын байр бий болгох чиглэлээр НҮБ-аас тусламж дэмжлэг үзүүлж байна. Арьс шир, нэхмэл сүлжмэл, мах, махан бүтээгдэхүүн, сүү цагаан идээний үйлдвэрлэл, мал аж ахуйн салбарын өртгийн сүлжээнд шинэ технологи нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах, инноваци, шинэлэг санаа туршин хэрэгжүүлэх зэргээр өвөрмөц өртгийн сүлжээг хөгжүүлэн бэхжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж байна. Мэдлэг-чадвар (know-how) хуваалцах болон чадавх бэхжүүлэх чиглэлээр цуврал олон арга хэмжээ зохион байгуулсны үр дүнд 2000 гаруй хүн, 14 байгууллага тодорхой туршлага сууж, ур чадвараа нэмэгдүүлсэн. Энэхүү арга хэмжээнд техник мэргэжлийн 18 төрлийн ур чадвар олгох цуврал сургалтууд, салбаруудын 17 удирдамж заавар, арга зүйн багцыг боловсруулан хэрэгжүүлсний зэрэгцээ судалгаа шинжилгээний болон хөгжлийн байгууллагууд, салбарын яамд, аж ахуйн нэгжүүд, бусад холбогдох талуудын институцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг ажлууд багтсан болно.

Түүнчлэн, Туршилтын үзүүлэн таниулах нэгжүүд, Нэхмэл сүлжмэлийн бэлэн бүтээгдэхүүний инкубаторын төв зэргийг байгуулах замаар жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд шинэ технологитой танилцах, нэвтрүүлэх, мэргэжлийн сургалтад хамрагдах боломжийг нээж өгсөн. Монголын мал аж ахуй, мах, махан бүтээгдэхүүн, сүү цагаан идээ, хүнсний ногооны өртгийн сүлжээг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд дэмжиж ажилласан. Тухайлбал, махны салбарт, НҮБ-ын тусламжтайгаар тоног төхөөрөмж, технологийн хангамжийг сайжруулснаар мах боловсруулах хүчин чадал 30 хувиар нэмэгдсэн. 11000 гаруй ажилчид орлогоо нэмэгдүүлж, 180,000 орчим хэрэглэгчдийн чанартай мах махан бүтээгдэхүүний хүртээмжийг сайжруулж чадсан байна.

Сүүлийн гурван жилийн хугацаанд зохистой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бий болгосны үр дүнд 160 гаруй газар тариалан эрхлэгчид, 500 гаруй ногоочдын орлого 30 хувиар өссөн байна. Түүнчлэн, Монгол Улс нь ноолуурын тогтвортой үйлдвэрлэлийг тэргүүлэгч орон болохын хувьд ноолуурын салбарын тогтвортой хөгжлийг өргөжүүлэн тэлэх зорилгоор салбарын яамд болон Ерөнхийлөгчийн Тамгын газрын тууштай дэмжлэгтэйгээр “Тогтвортой ноолуурын платформ”-ыг байгуулсан. Энэ нь олон улсын нэр хүндтэй брэнд болсон компаниудыг багтаасан хувийн хэвшлийн 20 гаруй компаниудын зөвшөөрөл, дэмжлэгийг хүлээн аваад байна. Олон улсын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон жижиглэнгийн худалдааны 20 гаруй компаниуд, түүний дотроос Kering Group (Gucci, Saint Laurent, Alexander McQueen брэндүүдийг эзэмшдэг), Textile Exchange (Нэхмэл эдлэлийн Бирж - 400 төрлийн брэнд эзэмшдэг), болон H&M зэрэг компаниуд Монгол Улсын байгальд ээлтэй, зохистой аргаар бэлтгэсэн ноолуурын ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн хамтын үйл ажиллагаанд оролцохоо илэрхийлээд байна.



Хог хаягдал, хорт бодисын менежмент


Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх хүрээнд үндэстний чадавхыг бэхжүүлэх, гар аргаар алт олборлогчид болон бичил уурхайн аргаар алт олборлогчдын мөнгөн усны хэрэглээг таслан зогсоох зорилгоор холбогдох хууль, тогтоомж, бодлогыг батлан хэрэгжүүлэхэд НҮБ-аас үзүүлэх тусламжаа өргөжүүллээ. Мөнгөн усны гол эх үүсвэрүүдийг шинжлэн судалж тодорхойлсны үндсэн дээр мөнгөн усны мэдээллийн санг байгуулсан болно.

2019 оны 8-р сард “Гар аргаар болон бичил уурхайн алт олборлолтын үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэстний хөтөлбөр” батлагдмагц Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хамтран үндэстний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулсан бөгөөд тус төлөвлөгөөний зохицуулалт, хэрэгжилтэд хяналт тавьж удирдлагаар хангах салбар дундын Ажлын хэсгийг байгууллаа.


Түүнчлэн, Органик бохирдуулагч бодисын тухай Стокгольмын конвенцийн дагуу Монгол Улс хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь хувь нэмэр оруулах зорилго агуулан байгаль орчинд ээлтэй хог хаягдлын менежментийг дэмжих, газрын тос, тоног төхөөрөмжид агуулагдсан полихлорт бифенилүүд (PCBs)-ийг устгахдаа Хог хаягдал шатаах үйлдвэрүүдэд (Open Burning Activities) Хамгийн боломжит арга технологи, Байгаль орчинд ээлтэй арга практикийг (BAT/BER) ашиглаж хорт бохирдлыг бууруулах Үзүүлэн таниулах цогц арга хэмжээ зохион байгуулах зэргээр НҮБ-аас туслалцаа үзүүлсэн болно. Энэхүү арга хэмжээнд нөхцөл байдлын шинжилгээ; өнөөгийн мөрдөж байгаа үндэстний болон олон улсын бодлого, хууль эрх зүйн зохицуулалтад хийх үнэлгээ; холбогдох загварууд; хог хаягдал, хогийн цэгийн менежмент; Монгол Улсын Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах зэрэг үйл ажиллагаануудыг хамруулж байна.

ЗОРИЛГО 1.1:


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, ХАМГИЙН ИХ 10 САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД

АХБ, ҮСХ, ЭМЯ, ХААХҮЯ, ХНХЯ, Стандарт хэмжил зүйн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Орон нутгийн захиргаад Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн, БСШУЯ, УБ хотын захиргаа, СЯ, МУИС, Онцгой байдлын ерөнхий газар, МАОЭНХ, МҮЭХ, МННХ/MSFA, Зохистой хөдөлмөрийн төлөөх Залуучуудын сүлжээ (DW4YN), Орхон аймгийн захиргаа, Орхон аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар

ЗОРИЛГО 1.2:



ЗОХИСТОЙ АЖЛЫН БАЙР, УР ЧАДВАРЫГ БИЙ БОЛГОХ, ЦЭВЭР ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ДОРОЙТОЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЗЭРЭГТ ЧИГЛЭСЭН НОГООН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСНИЙ СТРАТЕГИЙГ БОЛОВСРУУЛЖ МОНГОЛЫН ОНЦЛОГТ ТОХИРСОН, АРД ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ДАСАН ЗОХИЦОХ, ТҮҮНИЙ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХАНДЛАГЫГ НЭВТРҮҮЛЭХ

Агаарын бохирдлыг бууруулах талаарх бодлогын суурь мэдээллийг тодорхойлох

НҮБ-ын системийн байгууллагууд нь хот суурингийн агаарын бохирдлын олон давхар сорилт бэрхшээлтэй тэмцэх талаар Монгол Улсын Засгийн газартай хүчээ нэгтгэж нягт хамтран ажиллаж ирсэн. НҮБ нь агаарын бохирдлын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, агаарын бохирдолтой тэмцэх шинэлэг шийдлүүдийг туршихад техникийн туслалцаа үзүүлсэн. Агаарын бохирдлыг бууруулах үүрэг хариуцлага хүлээх институцийн бүтэц, 2010-2017 онуудад зарцуулсан төсвийн зарцуулалт зэрэгт цогц шинжилгээ хийсэн.

НҮБ-ын системийн байгууллагуудаас нярайн болон бага насны хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлоос учруулж буй уршиг нөлөөг нарийвчлан судалсан юм. Ихээхэн өндөр түвшинд хүрсэн Улаанбаатар хотын агаарын бохирдол нь нярайн болон бага насны хүүхдийн эрүүл мэндэд ноцтой үр дагавар үзүүлж байгааг шинжлэх ухааны үүднээс нотолсоны зэрэгцээ хувийн хэвшлийнхэнд ч агаарын бохирдлоос шалтгаалж шууд болон шууд бус өртөг зардал нэмэгдэж байгаа зэрэг нь стратегийн хийгээд шийдвэртэй арга хэмжээг даруй авах талаарх өргөн яриа хэлэлцүүлгийг өрнүүлэхэд хүргэсэн. Агаарын бохирдолтой холбоотой эрүүл мэндийн эрсдэлийн талаарх олон нийтийн ойлголт ч эрс нэмэгдсэн. Засгийн газрын холбогдох талууд ч баримталж буй стратегийн баримт бичгүүддээ шинжилгээ судалгаа хийж гарсан үр дүн зөвлөмжид үндэслэн өнөөгийн болоод цаашдын төлөвлөгөөндөө агаарын бохирдолтой тэмцэх тодорхой хувилбаруудыг тусган шинэчилж агаарын бохирдлын эрсдэлийг бууруулах талаар тодорхой алхам хийж эхэлсэн билээ. 2019 оны Дэлхийн байгаль орчны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор Цэвэр агаар-Залуучууд өдөрлөгийг НҮБХХ, НҮБ-ын Хүүхдийн Сан, ДЭМБ хамтран зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээ нь агаарын бохирдлын талаарх залуучуудын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд чиглэгдсэн.

Баянхонгор аймгийн засаг захиргаатай хамтран, ерөнхий боловсролын ахлах сургуулийн 600 гаруй хүүхдүүд, олон нийтийн сайн дурын ажилтнуудад зориулж сайн дурын ажлын тухай болон агаарын бохирдлын үр дагаврын талаар сургалт явуулсан. Энэхүү сургалтын үр дүнд, сургалтад оролцогсад өөрсдийн үе тэнгийнхэн болон орон нутгийн иргэдэд агаарын бохирдлын талаарх мэдээ мэдээлэл хүргэх арга хэмжээг зохион байгуулах ерөнхий боловсролын сургуулийн болон олон нийтийн сайн дурын бүлгүүдийг байгуулж эхэлсэн. Мөн сайн дурын ажил хийж буй залуучууд

агаарын бохирдлын талаар блог бичиж, видео блог хийж мэдээллийн нийгмийн сүлжээгээр цацагдаж байсан. Олон нийтэд чиглэсэн эдгээр арга хэмжээний үр нөлөө салбарлан түгж 5850 хүнд хүрсэн бөгөөд эдгээр хүмүүсийн нэлээд хэсэг нь сайн дурын бүлгүүдэд элсэн орж байна.

Нөөц баялгийн зохистой менежмент

НҮБ нь Монгол Улсын Баруун бүсийн гурван хэсэг нутаг дэвсгэрт газрын тогтвортой менежментийн сайн арга дадлыг хэрэгжүүлж хэвшүүлэх үүднээс уул уурхайн гурван компанитай хамтран ажиллаж байгаа бөгөөд орон нутгийн засаг захиргаад, нутгийн иргэд мөн төсөл хэрэгжүүлэгч бусад талуудтайгаа нягт хамтран ажиллаж байна. Бэлчээрийг сэлгэн ашиглах, усны эх үүсвэрийг хамгаалах, тариалангийн талбайн нөхөн сэргээлт, ой үржүүлэг зэрэг газрын тогтвортой менежментийн сайн арга дадлыг Монгол Улсын Баруун бүсийн 78600 га нутаг дэвсгэрт нэвтрүүлээд байна. Чадавч бэхжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлсний үр дүнд орон нутгийн иргэдийн газар ашиглалтын төлбөр, газрын тогтвортой менежментийн талаарх ойлголтын түвшин төсөл хэрэгжүүлэхээс өмнөх түвшинтэй харьцуулахад хоёр дахин сайжирсан байна. Ингэснээр нилээд хэмжээний газар нутгийг (5.7 сая га) улсын болон орон нутгийн хамгаалалтад авахаар батламжлуулаад байна.

НҮБ-ын Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хөтөлбөрийг (UN-REDD) амжилттай хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын Засгийн газар Ойн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний стратеги (REDD+), түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь байгаль орчны ээлтэй орчинг бүрдүүлж, орон нутгийн ой ашиглагчдын бүлгүүд (ОАБ/FUGs) болон жижиг, дунд үйлдвэрүүд (ЖДҮ)-ийн чадавчыг бэхжүүлэх замаар ойн тогтвортой менежментэд тэдний оролцоог нэмэгдүүлэхэд оршиж байгаа юм. Үүнтэй холбоотойгоор Монгол Улс нь Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь Конвенцийн (UNFCCC) хүрээнд Варшавын хэлэлцээрийн заалтын дагуу дөрвөн гол элементүүдийг үйл ажиллагаа болгох, үр дүнд суурилсан REDD+ төлбөрт хамрагдахад тун ойрхон байгаа бөгөөд ингэх тохиолдолд орон нутгийн иргэд, орон нутгийн ой ашиглагчдын бүлгүүд ашиг шимийг илүү хүртэнэ. Сэргээгдэх эрчим хүчийг худгийн насост ашиглах, мал аж ахуйн арга техникийг сайжруулах, цөөн тооны ашиг шим сайтай мал сүрэгт тохирсон бэлчээрийн менежментийг нэвтрүүлэх зэргээр мал аж ахуйн үйлдвэрлэлийг бэхжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн уур амьсгалын өөрчлөлтийг тооцсон ухаалаг арга техникийг туршиж байна.

Эрчим хүч хэмнэлт

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Баянхонгор аймаг агаарын бохирдлоос эх, хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор 2019-2022 онуудад “Утаагүй Баянхонгор” Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд орон нутгийн засаг захиргаа, Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургууль, НҮБ-ын байгууллагууд хамтран гэр хорооллын айл өрхөд зориулан эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаалт, хоол бэлтгэлийн төхөөрөмж, дулаалгын материал, агаар сэлгэлтийн төхөөрөмжөөс бүрдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний (ХХДБҮ/CHIPS) багцыг хөгжүүлэн туршиж эхлээд байна. Хандивлагч хэд хэдэн байгууллагууд болон аймгийн засаг захиргааны дэмжлэгтэйгээр тус багцыг 2019 онд 230 гаруй айл өрх ашиглаж эхэлсэн нь аймгийн төвийн агаарын бохирдлыг бууруулах, айл гэрийн дотоод агаарын чанарыг сайжруулахад ихээхэн хувь нэмэртэй туршилт болж байна. Энэхүү ХХДБҮ-ний багцын үр нөлөө, айл гэрийн

дотоод агаарын чанарт (ДАЧ/IAQ) хяналт шинжилгээ хийх зорилгоор НҮБ нь Пенсильваны их сургууль болон Сент-Луисын Вашингтоны их сургууль зэрэгтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд туршилтад хамрагдсан айл өрхөд дулааныг хянах мэдрэгч, гэр доторх агаарын чанарын мэдрэгчийг суурилуулсан. Түүнчлэн Баянхонгор аймгийн гэр хороололд Инновацийн төвийг нээж ажиллуулснаар эрчим хүч, халаалтын технологи, эрчим хүч хэмнэлт, хэрэглээ, ХХДБҮ багц, сайн туршлагаудын талаар орон нутгийн иргэдэд зөвлөгөө өгч үйлчилж байна.

Эдгээр эрчим хүч хэмнэлтийг дэмжих туршилтын төслүүдийг хэрэгжүүлснээр 2019 онд ойролцоогоор 5,220 тонн CO₂-эkv хүлэмжийн хийг бууруулсан байна. Эдгээр төслийн хүрээнд 24 угсармал барилгад техникийн шинэчлэлийг хийлээ. Тухайлбал, Эрчим хүчний зохицуулах хорооны (ЭХЗХ/ERC) байрны дээвэрт нарны эрчим хүч хураагуурын системийг суурилуулсан нь ЭХЗХ-ны эрчим хүчний жилийн хэрэглээний 60 хувийг хангаж байна. Хөрөнгө оруулалтын өгөөжийг ийнхүү тун богино хугацаанд



өгч эхэлж байгаа нь төрийн өмчийн бусад олон барилга байгууламжид энэхүү системийг суурилуулах боломж байгааг илэрхийлж өгсөн. НҮБ-ын зүгээс эрчим хүчний үр ашгийг сайжруулах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд үндэстний хэмжээнд мэргэжлийн чадавх сайжирч, барилга байгууламжийн норм, стандартыг шинэчилж байна.


Техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлж ирсний үр дүнд Монгол Улсад Цөмийн шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөц сайжирсан. Техникийн туслалцааны хөтөлбөрийн хүрээнд Нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулахын тулд үйлдвэрлэлийн илүүдэл хийг боловсруулах цахилгаан дамжуулгын хүчин чадлыг (Electron Beam Capacities) ашиглах шийдлийг туршихад НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлсэн болно. Цөмийн шинжлэх ухаан, технологийг аюулгүй, найдвартай ашиглах зорилгоор хүний нөөцийг хөгжүүлэх стратегийг боловсруулаад байна. 2019 онд цөмийн шинжлэх ухаан, инженер технологийн чиглэлээрх сургалтын чанар сайжирсны зэрэгцээ Монгол Улсын Их сургуулийн багш сургагчдыг зөвлөх үйлчилгээ, эрдэм шинжилгээний ажлаар томиллоор ажиллуулах, тэтгэлэгт хөтөлбөр, сургалтуудад хамруулах зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний үр дүнд тэдний мэргэжлийн мэдлэг, чадвар дээшилж байна.

Ногоон хөгжлийн хөтөлбөрийг дэмжих


Хэд хэдэн аймгууд өөрийн аймгийн Ногоон хөгжлийн баримт бичгийг боловсруулсан. Тухайлбал, Орхон аймаг 2019 онд “Орхон аймаг, Эрдэнэт хотын Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт 2025” хэмээх баримт бичгийг баталж, түүндээ орон нутгийн ард иргэдийн амьжиргаа, тогтвортой байдлыг хангах цогц арга хэмжээг тусгаад байна. Энэхүү урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтээ ногоон, тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй нийцүүлэн өөрийн аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчин, засаглал гэсэн хөгжлийн дөрвөн тэргүүлэх чиглэлийн хүрээнд 16 зорилго, 49 зорилт, 86 шалгуур үзүүлэлт, 246 үйл ажиллагааг тодорхойлсон. Орхон аймгийн энэхүү туршлагад суурилан Сүхбаатар, Увс аймгууд урт хугацааны хөгжлийн алсын хараатай байх талаар орон нутагтаа яриа хэлэлцүүлгийг өрнүүлж эхэлсний зэрэгцээ ногоон хөгжлийн зарчим, ТХЗ-той нийцүүлэн аймгийнхаа хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан батлаад байна.

ЗОРИЛГО 1.2:


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, ХАМГИЙН ИХ 10 САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД:

ОБЕГ, БОАЖЯ, Орон нутгийн захиргаад, БХБЯ, ОУБОТТ, Азийн сан, УУХҮЯ, МУИС-ын Цөмийн физикийн судалгааны төв, ХХААХҮЯ, МҮЭНХ, МАОЭНХ, ХНХЯ

ЗОРИЛГО 1.3:



ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ЯДУУ, ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮН АМЫН АМЬЖИРГААГ ТЭТГЭДЭГ ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХАМГААЛАХ

Экосистем болон байгалийн нөөцийн менежмент

НҮБ-ын дэмжлэгтэйгээр, генетик нөөц болон түүнтэй хамааралтай уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр ашгийг хуваалцах талаарх ойлголтыг шинэчлэн боловсруулсан хуулийн төсөлд тусгаж, 2020 онд УИХ-д батлуулахаар өргөн барьсан. Хуулийн төсөлд орсон заалтууд нь хөдөө аж ахуй, эмийн үйлдвэрлэл, биотехнологийн салбарт генетик нөөцийг ашигласнаас гарах үр ашгийг шударгаар хуваалцах замаар тэдгээр нөөцийг ханган нийлүүлэгчдэд мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр ашиг шимийг нь буцааж хүртээх боломжийг бүрдүүлж байгаа юм. Байгалийн нөөцийн менежментэд цогц арга барилаар хандах, газрын доройтлыг бууруулж нөхөн сэргээх даян дэлхийн хамтын ажиллагаанд хувь нэмрээ оруулахад НҮБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн газрын доройтлыг хязгаарлахад чиглэсэн арга хэмжээнүүд ашиг тусаа өгсөн болохыг хөндлөнгийн үнэлгээний тайланд тэмдэглэсэн байна.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулсан Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Газрын тухай хууль, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль зэрэгт газрыг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн нөхөн төлбөрийн механизмыг тусгасан нэмэлт өөрчлөлтүүдийг УИХ-аар 2020 онд хянаж батална. Судалгаанаас үзэхэд уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор газрыг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн нөхөн төлбөрийн механизмын ашиг тусын талаарх олон нийтийн ойлголт аймгийн төвд 10 хувиар; бэлчээрийн нутаг



дэвсгэрийг хамгаалах туршилтын төсөл хэрэгжүүлж байгаа газруудад 30 хувиар; газрын тогтвортой менежментийн шинэ технологийг ашиглаж байгаа зорилтот малчдын дунд 50 хувиар тус тус нэмэгдсэн байна.

НҮБ-аас хэрэгжүүлж байгаа уул уурхайн салбарын байгаль орчны засаглалыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны баталсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамд хэд хэдэн өөрчлөлт оруулж, уул уурхайн компаниуд байгаль орчны асуудал хариуцсан ажилтантай байх хийгээд гомдол зарга шийдвэрлэх механизмыг чанд мөрдөхийг зүйлчилж өгсөн. Оролцогч талуудын дунд итгэлцлийг бий болгох, байгаль орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн үр дүнг сайжруулах хэрэгсэл болгон оролцоог хангасан байгаль орчны хяналт шинжилгээний талаарх ойлголтыг Монголд Улсад нэвтрүүлэн хэвшүүлж эхлээд байна.

Монгол Улсын газар нутгийн тогтвортой байдал, гамшгийн эрсдэлийг сөрөх чадавхыг бүрдүүлэх чиглэлээр НҮБ-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлж байгаа аймгуудын бэлчээр ашиглагч 50 бүлгийн малчдын чадавхыг дээшлүүлэхэд зориулж тогтвортой мал аж ахуй эрхлэлт, ногоон хөгжил, улирлын чанартай отор нүүдэл, малын тоо толгойг тодорхой тоонд хязгаарласнаар биологийн олон янз байдлыг хамгаалах боломж зэрэг олон асуудлыг хамруулсан арга хэмжээг зохион байгууллаа. Төсөл хэрэгжүүлж байгаа аймаг сумдын 9000 орчим малчидтай тулж зөвлөлдөн ажиллаа. Төсөлд хамрагдсан нутаг дэвсгэрийн ойн сангийн биологийн олон янз байдлыг хамгаалахын тулд ойн нөөц ашиглалтын татвар, тооллогын механизмын асуудлаар олон уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан нь орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах үндэс суурийг тавьсан.


Ойн тогтвортой менежмент

Монгол Улсын ойн санг үр ашигтай, зохистойгоор удирдахад чиглүүлж Монгол Улсын Засгийн газар, төрийн бус байгууллагууд, ой ашиглагч бүлгүүдэд НҮБ-аас дэмжлэг үзүүлэх замаар экосистемийн олон төрлийн үйлчилгээ, ашиг тусыг дэмжин хамгаалах, түүний дотор биологийн олон янз байдлыг хамгаалах, ойн доройтлыг хязгаарлах, улмаар уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг сөрөх чадавхыг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ойн нөхөн сэргээлт, үржүүлэг, бүтэц, эрүүл орчин, чанарыг сайжруулахад анхаарал хандуулж байгаагийн зэрэгцээ биологийн олон янз байдал, ойн сангийн нүүрстөрөгчийн нөөцлөлтийг хамгаалах асуудлыг ойн түймрээс сэргийлэх, ойн цэвэрлэгээ, сийрүүлэг хийх зэрэг үйл ажиллагаатай уялдуулж ард иргэдийн хэрэгцээг хангах арга хэмжээ авч байна.


Бодлогын нөлөөлөл үзүүлэх замаар улсын хэмжээнд Ойн тогтвортой менежмент (ОТМ/ SFM)-ийг дэмжих, түүнчлэн ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх туршилтын төслийг хэрэгжүүлэх замаар аймаг, сумдад газрын менежментийн зохистой дадлыг бий болгоход чиглэсэн дэмжлэг үзүүллээ. Таван аймгийн хоёр сая га нутаг дэвсгэрт оролцоог хангасан ойн менежментийг сайжруулах, улмаар биологийн олон янз байдлыг хамгаалахад хувь нэмэр оруулсан байна. Ойн сан дахь нүүрстөрөгчийн хэмжилтийг шинжилж үзэхэд хөрс, био масс дахь нүүрстөрөгчийн нөөцлөлтийн чанар 101 ой ашиглагчдын бүлгүүдэд 1.35 tCO₂e-ээр сайжирсан байна.

ЗОРИЛГО 1.3 :


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭ



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД: БОАЖЯ, ОАБ, БСШУСЯ, ХХААХҮЯ

ЗОРИЛГО 1.4:



World Health Organization




НУТГИЙН ИРГЭДИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ

Гамшгийн эрсдэлийг бууруулах, даван туулах

Малчин айл өрхүүдийг цаг агаарын аюулт үзэгдэл, зудын аюул уршгаас урьдчилан сэрэмжлүүлэх зорилгоор үндэстний болон олон улсын хөгжлийн байгууллагууд хамтран мал сүргийг хамгаалах замаар малчдын амьжиргааг дэмжих хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүллээ. Хахир хүйтэн өвлийн улирлыг даван гарахад нь малчдад туслах, хоол хүнс, тэжээлийнх нь аюулгүй байдлыг хангах зорилгоор 5 аймгийн 25 сум, нийслэлийн 1000 гаруй эмзэг бүлгийн малчин өрхөд мөнгөн тусламж үзүүлж тэднийг гамшгаас эрт сэрэмжлүүлэн хамгаалах арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийн судалгаа явуулж дээрх арга хэмжээний үр нөлөөнд үнэлгээ хийж үзэхэд үр ашиг, зардлын харьцаа 7.1 байсан нь эрт сэрэмжлүүлгийн арга хэмжээ хамгийн үр ашигтай болохыг нотолж байна. Зудын эрсдэлийн тандан судалгаа явуулах, бэлэн байдлыг хангахад зориулж техникийн туслалцаа үзүүлсэн. Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), Цаг уур, орчны шинжилгээний газар (УЦОШГ) зэрэг байгууллагуудад ган, зуд гэх мэт цаг агаарын аюулт үзэгдлийн тохиолдол, давтамжид хяналт шинжилгээ хийх, эрт сэрэмжлүүлгийн дохиолол хийгээд гамшгийн хор хохирлыг тооцоолох автомат дохиоллын горимыг хөгжүүлэн суурилуулах зэргээр өнөөгийн системийг шинэчлэх, чадавхыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллаа.

Улаанбаатар хотын хэмжээнд болон гэр хорооллын уур амьсгалын өөрчлөлт, тохиож болзошгүй үерийн нөлөөллийг урьдчилан тооцоолох загварчлал, Улаанбаатар хотын хойд хэсгийн гэр хорооллууд болон зорилтот 10 дэд хороололд үерийн эрсдэлийг бууруулах, барилга байгууламжийн гамшгийн эрсдэлийг тэсвэрлэх чадварыг сайжруулахад чиглэсэн газар ашиглалтын төлөвлөлтийн загварчлал зэргийг боловсруулж эхэлсэн. Зорилтот дэд хорооллуудын болзошгүй үерийн гамшгийг гэтлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, сургалтууд болоод ур чадварыг бий болгох арга хэмжээнүүдийг дэд хорооллын иргэдтэй хамтран хэрэгжүүлж байна. Төсөл хэрэгжүүлж байгаа хорооллуудад гидрологийн судалгаа хийж, үерийн эрсдэлийг бууруулах зорилгоор цаашид барих шаардлагатай үерийн хамгаалалтын байгууламжийн хэрэгцээг тодорхойлсон.

НҮБ нь техникийн туслалцааны хөтөлбөрөө үндэстний хэмжээний эрүүл мэндийн аюулгүй байдлын төлөвлөгөө хийгээд гамшгийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад чиглүүлэн өргөтгөж цар тахлын эсрэг тэмцэх, бэлэн байдлыг хангах зорилгоор үндэстний хэмжээний зохицуулалтын механизмыг байгуулах



өргөн цар хүрээний ажиллагаа явуулах, улмаар гамшгийн хор хохирлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө, эрсдэлийн үнэлгээ хийх зэрэгт дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн эрүүл мэндийн яаралтай тусламжийн төвүүдийг байгуулж эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангах, гамшгийн эсрэг хариу арга хэмжээг бусад салбарууд, оролцогч талууд, түншүүдтэй хамтран авах боломжийг бүрдүүлж өгсөн. Монгол Улсад цар тахлын аюултай тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөөг нийт салбарууд, иргэний нийгэм, ТББ, хувийн хэвшил, эрүүл мэндийн салбарынхантай түншлэгч талууд зэргийн төлөөлөлтэй хамтран үндэстний болоод орон нутгийн эрсдэлийн менежментийн төлөвлөлт, үйл ажиллагаа, бүтэцтэй уялдуулж өгсөн. Монгол Улсын цар тахлын эрсдэлийн үнэлгээ, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн үнэлгээ, шаардагдах хөрөнгийн тооцоо, арга хэмжээний нөлөөллийн үнэлгээ, загварчлал зэрэг нь уг төлөвлөгөөг бодит баримт бичиг болгоход үр дүн үзүүлсэн.

Гамшгийн эрсдэлийг сөрөх нийгмийн бүлгүүдийн чадвар, бэлэн байдал


Тэгш бус байдлыг багасгах зорилгоор шилжих хөдөлгөөнд оролцогсдыг сайн дурын үндсэн дээр уугуул нутагтаа эргэн очих, хэдийгээр уугуул нутагруугаа буцаж шилжих сонирхолтой байгаа боловч хөрөнгө мөнгө дутагдалтайгаас боломжгүй болсон хүмүүс зэрэгт дэмжлэг үзүүлэх замаар хүн амын дотоод шилжих хөдөлгөөнийг (хөдөөгөөс хот руу чиглэсэн) зохицуулах чиглэлээр НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлж байна. Уугуул нутагруугаа буцах шилжих хөдөлгөөнд оролцогсдыг дэмжих зорилгоор хувцас оёдол, засварын бизнес, тээврийн үйлчилгээ эрхлэх, хоолны газар ажиллуулах, мал аж ахуй эрхлэх, мужааны цех ажиллуулах зэрэг төрөл бүрийн хувиараа хөдөлмөр эрхлэх санал санаачилгыг нь дэмжиж тэтгэлэг олгосон.

Эдгээр арга хэмжээний үр дүнд дотоод шилжилт хөдөлгөөний хандлагын талаарх ойлголт, түүнийг удирдан зохицуулах чадвар ихээхэн сайжирсан бөгөөд шилжилт хөдөлгөөний талаарх тодорхой асуултуудыг ҮСХ-ноос явуулдаг хүн амын тооллогын асуулгад тусгаж чадсан нь томоохон ахиц юм. Төрийн албаны 1200 орчим албан хаагчид чадавч бэхжүүлэх цуврал сургалтууд, тооцоо загварчлалын семинаруудад хамрагдсанаар тодорхой цаг хугацааны хүн ам зүйн мэдээллийг цуглуулан боловсруулж гамшгийн бэлэн байдал болон гамшигтай тэмцэх үеийн арга хэмжээг төлөвлөхөд ашиглах сайн туршлагатай танилцсан болно. Эдгээр сургалтын үеэр тодорхой цаг хугацаанд шилжих хөдөлгөөнд орсон хүн амын тоо, үндсэн байршил, шилжин очсон газар, дотооддоо шилжилт хөдөлгөөнд оролцоход нөлөөлж буй гол хүчин зүйлүүд зэрэг үзүүлэлтүүдээр 5 удаа үнэлгээ хийсэн.


Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлэх, стратегийн төлөвлөгөө боловсруулах, улмаар гар, хөл, амны өвчин, песте дэс петицид (PPR) зэрэг хил дамжсан мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх зэрэг чиглэлээр Мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлдэг төрийн байгууллагад НҮБ-аас техникийн тусалцаа үзүүлсэн. Нийт 331 сумаас 295 сумынх нь мал эмнэлгийн эмч ажилчдыг сургалтад хамруулсан бөгөөд малчид, олон нийтийн мал, амьтны гоц халдварт өвчний талаарх ойлголт мэдлэг нөлөөлөл сурталчилгааны олон үйл ажиллагааны үр дүнд сайжирсан. Хөдөө аж ахуйн салбарын чадавчыг бэхжүүлж гамшгийн хийгээд уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх чадавчыг бэхжүүлэх, эрсдэлийн талаарх мэдээллийг ашиглан Гамшгийн эрсдэлийг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг хэрэгжүүлж улмаар Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх, ТХЗ-ын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, тайлагналтад бодит хувь нэмэр оруулах зорилго агуулан Монгол Улсын мал аж ахуйн салбарын эрсдэлийн урьдчилсан үнэлгээг хийсэн.

ЗОРИЛГО 1.4:


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД:

БОАЖА, ОАБ, БСШУСЯ, ХХААХҮЯ, Адвентист Хөгжил ба Туслалцааны Байгууллага (ADRA), Дэлхийн зөн, Улаан загалмайн нийгэмлэг, ОБЕГ, Хүүхдийг Ивээх Сан, Мерси Корпус

ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ ХОЁР:



World Health
Organization



UN HABITAT
FOR A BETTER URBAN FUTURE

IOM
UN MIGRATION



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ, ЧАНАРТАЙ, ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БИЙ БОЛГОХ



ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ:

2021 ОН ГЭХЭД ЯДУУ БОЛОН ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮН АМ НИЙГМИЙН САЙН ХАМГААЛАЛТААС АШИГ ТУС ХҮРТЭЖ, ЧАНАРТАЙ, ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР, ЯЛАНГУЯА, УНДНЫ УС, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ИЛҮҮТЭЙ ХАНГАГДАНА

Тогтвортой хөгжлийн зорилго болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ийг иш үндэс болгон эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, ундны ус, ариутгал, ариун цэврийн байгууламж, нийгмийн хамгаалал зэрэг чанартай, тэгш хүртээмжтэй нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах чиглэлээр НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт үзүүлэх дэмжлэгээ үргэлжлүүлж байна. НҮБ-ын системийн 10 байгууллага нийтдээ 31.05 сая ам.долларын хөрөнгийн санхүүжилтийг босгосноос 20.49 сая ам.долларын хөрөнгийг түншлэгч 23 байгууллагатай хамтран 13 аймаг, нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжүүлж байгаа 25 төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд зарцуулсан. Нийт зарцуулсан хөрөнгийн дийлэнх хувийг ТХЗ 3 – Эрүүл мэндийг дэмжих (62 хувь), ТХЗ 4 – Чанартай боловсролыг дэмжих (14.5 хувь), ТХЗ 2 – Өлсгөлөнг эцэслэх (13 хувь), ТХЗ 6 – Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах (9 хувь) зэрэг дөрвөн ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Үндэсний хэмжээний гол шалгуур үзүүлэлтүүд

2018 онд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 16.9, 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 27 байна¹. 2018 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны (SISS/MICS 6) шинэчлэгдсэн мэдээллээс үзэхэд ундны ус, ариун цэврийн байгууламжийн сайжруулсан эх үүсвэр, үйлчилгээний хүртээмж хүн амын дунд тэгш бус байна. 2018 оны байдлаар ундны усны эх үүсвэрт холбогдсон хүн амын хувийн жин 64 хувиас 82.5 хувь² болж нэмэгдсэн бөгөөд, ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээнд холбогдсон хүн амын хувийн жин 2016 оны суурь үзүүлэлт болох 59 хувиас 69 хувь³ болж өссөн байна. Гэсэн хэдий ч судалгааны явцад ундны усны үйлчилгээний чанарын үзүүлэлтийг шинжилж үзэхэд ундны усны баталгаатай үйлчилгээ авч байгаа хүн амын хувийн жин 22 хувь⁴ болж буурчээ.

Боловсролын үзүүлэлтүүд 90-ээс дээш хувьтай байгаа бөгөөд хөвгүүдийн 95 хувь, охидын 97 хувь нь ерөнхий боловсролын бага сургуульд, хөвгүүдийн 92 хувь, охидын 94 хувь нь ерөнхий боловсролын дунд сургуульд тус тус хамрагдаж байна⁵. Гэхдээ бараг нийт хүүхдүүд ерөнхий боловсролын бага сургуульд хамрагдаж байгаа боловч 7-14 насны нийт хүүхдийн дөнгөж 62 хувь нь хялбар текстийг уншиж ойлгож чадаж байгаа бол дөнгөж 52 хувь нь тоо бодлогын суурь ойлголттой байна. Тав хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн байдлыг судалж үзэхэд 1.8 хувь нь жингийн дутагдалтай, 9 хувь нь өсөлт хоцролтой, 0.9 хувь нь тураалтай, 10.5 хувь нь жингийн илүүдэлтэй байна⁶.

Эрүүл мэнд

Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, хүн бүрийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулахыг тэргүүлэх чиглэл болгон Хүн амын эрүүл мэндийн талаар Монгол Улсын төрөөс баримтлах бодлого болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан, ОУАЭА нь Монгол Улсын Засгийн газар болон бусад оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж байна. Эдгээр хүчин чармайлтын үр дүнд уушгины хатгалгаанаас сэргийлэх вакцин (PCV)-ы дархлаажуулалт, бичил тэжээл, жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг худалдан авах төсөв хөрөнгө Монгол Улсын эрүүл мэндийн салбарын төсөвт тусгагдсан. Тоо мэдээллийн олдоц, чанарт ч томоохон ахиц гарсан. Олон жил уйгагүй хийсэн судалгаа шинжилгээний ажил, НҮБ-аас гаргасан зөвлөмж, ЭМЯ, ҮСХ, Иргэний бүртгэлийн газар зэрэг байгууллагуудын нягт хамтын ажиллагааны үр дүнд шинээр төрсөн хүүхдийг төрсөн даруйд нь албан ёсны бүртгэлд хамруулах журам хэрэгжиж эхэлсэн. Энэ нь төрөлтийн бүртгэлийг үнэн зөв, бодитой болгож, шинээр мэндэлсэн хүүхэд төрсөн даруйдаа нийгмийн хамгаалалд хамрагдаж эхлэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

Эрүүл мэндийн тогтолцоонд салбар-хоорондын хийгээд төрөл бүрийн мэргэжлийн арга хандлагыг нэвтрүүлснээр эмзэг бүлгийн хүн амд тулгарч буй олон хүчин зүйлсийг үр дүнтэйгээр шийдвэрлэхэд тус дөхөм болж байна. Эрүүл мэндийн салбарын чадавхыг дээшлүүлснээр хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг хангахад чухал түлхэц болж байна.

¹ ЭМЯ, <https://www.chd.mohs.mn/2019/sariin%20medee/2018eng.pdf>

² ҮСХ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын ХС, https://mics-surveys-prod.s3.amazonaws.com/MICS6/East%20Asia%20and%20the%20Pacific/Mongolia/2018/Survey%20findings/SISS2018-MICS6%205FR_English.pdf

³ мөн адил

⁴ мөн адил

⁵ мөн адил

⁶ мөн адил

Агаарын бохирдлын талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр НҮБ-ын системийн байгууллагууд хамтран ажиллаж энэ чиглэлээрх бодит мэдээллийг бүрдүүлж, бодлогын арга хэмжээ авах хэрэгцээ шаардлага зайлшгүй байгааг гаргаж тавих, ялангуяа, хүүхэд, жирэмсэн эхчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа агаарын бохирдлыг бууруулахад улс төрийн үүрэг хариуцлага хүлээх хэрэгтэй болсныг илэрхийлсэн (ТХЗ 3 - Эрүүл мэндийг дэмжих, ТХЗ 7 – Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх). Ийнхүү НҮБ-ын системийн байгууллагуудаас явуулсан нөлөөлөл сурталчилгааны ажлын үр дүнд агаарын бохирдолтой холбоотой асуудлыг өвлийн улиралд хэрхэн шийдвэрлэх талаар Эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгаж чадсан.

НҮБ-аас хүн амын эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн хөдөлгөөнт тусламж үйлчилгээ, телемедицин зэрэг үйлчилгээний шинэлэг хэлбэрийг хөгжүүлэх, орчин үеийн эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэхийн тулд цөмийн анагаах ухааны арга технологийг олон улсын хэм хэмжээ стандарт, зөвлөмж удирдамж, худалдан авалтын хамгийн үр дүнтэй арга хэлбэрт нийцүүлэн ашиглах зэрэгт анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Чанартай боловсролыг дэмжих

Хүн амын боловсролыг дэмжих хүрээнд сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролоос эхлээд дээд боловсрол хүртэлх бүх шатны боловсролын түвшинд хэрэгжиж байгаа салбарын төлөвлөлт, бодлого, хөтөлбөрүүдэд ТХЗ 4-ийг тусгахад чиглэсэн үйл ажиллагааг НҮБ-ын зүгээс дэмжин ажиллаж байна. НҮБ-ын системийн байгууллагууд нь хөгжлийн түншүүдтэйгээ хамтран Боловсролын салбарын бодлогод иж бүрэн үнэлгээ хийж Монгол Улсын Засгийн газраас боловсролын талаар хэрэгжүүлэх арга хэмжээний бодлогын зөвлөмжийг гаргасан. Энэхүү үнэлгээнд боловсролын үйлчилгээний хүртээмж, тэгш шударга байдал, хамралт, чанар, насан туршийн боловсрол зэрэг Монгол Улсын боловсролын тогтолцоонд хамаарах бүхий л асуудлыг хамруулсан болно.

Боловсролын тогтолцоонд илүү бодитой хяналт үнэлгээ хийх зорилго бүхий боловсролын менежментийн мэдээллийн системийг 2017-2018 онд байгуулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн. Боловсролын салбарын бодлогод хийсэн үнэлгээний үр дүн, зөвлөмжийг үндэслэн АХБ манлайлж Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA), НҮБ-ын Боловсрол шинжлэх ухаан соёлын байгууллага (НҮБ БШУСБ), НҮБ-ын Хүүхдийн сан (НҮБ ХС), Дэлхийн банк зэрэг байгууллагуудын оролцоотойгоор Боловсролын салбарын 2020-2030 оны мастер төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлж байна.

Түүнчлэн ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан Мэдээллийн технологийн чадавхын үндэсний стандарт боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран Техник мэргэжлийн боловсрол, сургалт болон ур чадварын сургалтын талаарх бодлогод үнэлгээ хийж бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан. Боловсролын тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ чанартай, тэгш хүртээмжтэй боловсролыг дэмжих зорилгоор бусад салбарууд, олон нийт, оюутан сурагчид, эцэг эхчүүдтэй нягт хамтран ажиллахыг дэмжиж байна. Түүнчлэн Монгол Улсын дээд боловсролын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, тэдний олгож байгаа мэргэжил мэргэшлийн стандартыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр НҮБ-аас дэмжлэг үзүүлж байна.

Ундны ус, ариутгал, ариун цэврийн байгууламж

НҮБ нь хүн амыг баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах (ТХЗ-6) зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилтот түвшинд хүрэх үндэсний стратегийг бэхжүүлэхэд онцгойлон анхаарч байна. Ингэхийн тулд засаглалын механизмыг бэхжүүлэх, байгаль орчны аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхтайгаар тогтвортой хөгжихөд шаардагдах элементүүдийг бүрдүүлж хүн амын хамгийн эмзэг хэсэгт хүрч ажиллахад гол анхаарлаа хандуулж байна. НҮБ-ын системийн байгууллагууд нь орон нутгийн ард иргэд, айл өрх, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагуудтай нягт тулж ажиллан тэдэнд ундны ус, ариун цэврийн байгууламжийн талаарх аливаа шийдвэр гаргахад зохицуулалттай, уялдаа холбоотойгоор оролцох боломжийг нээхийг зорьж байна. Орон нутгийн ард иргэдийн оролцоотойгоор ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр орууллаа. НҮБ-ын системийн байгууллагууд хамтран Монгол Улсын Засгийн газарт ундны ус, ариун цэврийн байгууламжийн талаарх бодлого, хөтөлбөрийг ТХЗ-той нийцүүлэхэд дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд засгийн газрын төлөвлөлт, хяналт шинжилгээний тогтолцооны хүрээнд баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжийн зохистой удирдлагын талаарх ойлголтыг нэвтрүүлсэн нь эхний алхам болж байна.

Хүнсний чанарыг сайжруулах

Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, хоол тэжээлийн байдлыг сайжруулах зорилгоор хүнсний үйлдвэрлэл, баяжуулалт, чанарын хяналтын механизмыг боловсронгуй болгох чиглэлээр НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлж байна. Энэ хүрээнд Баяжуулсан хүнсний тухай хууль, хүүхдийн хоол тэжээлийн байдалд хяналт, шалгалт хийх журам, хоол тэжээлийн хүнд хэлбэрийн дутлын үед авах арга хэмжээний талаарх протокол зэргийг боловсруулан батлуулж, хүнсний ногооны салбарын холбогдох хууль, тогтоомж боловсруулах зэрэг үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлсэн. Хөдөө аж ахуйн салбарын бүтээмж, улмаар хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангах үндэсний тогтолцоог сайжруулах чиглэлээр томоохон ахиц дэвшил гарсан. Хил дамнасан мал, амьтны өвчний оношилгоо, урьдчилан сэргийлэлт; бохирдуулагч бодисыг шинжлэн илрүүлж хүнсний аюулгүй байдлыг хангах чадвар; хүнсний хяналтын удирдлагын систем; хөдөө аж ахуйн салбарын инноваци, дижитал технологийг дэмжих талаарх үндэсний чадавх бэхжиж байна. Хүнсний чанар, тэр дундаа таримал ургамлын үр, сортын тухай хууль; Хүнс, хөдөө аж ахуйн мал, амьтны генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ (AnGR); хил дамнасан мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратеги; “жимс, жимсгэнэ” үндэсний стратеги зэрэг үндэсний хэмжээний бодлого, стратегийг сайжруулахад НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлж байна.


Нийгмийн хамгаалал

Монгол Улс дахь НҮБ нь нийгмийн хамгааллыг эрхэмлэн аливаа ялгаварлал, гадуурхал, доромжлолыг үл тэвчиж орлогын аюулгүй байдлыг хангах, хүний эрхийг хамгаалахад онцгой анхаарал хандуулж ирсэн. НҮБ-ын Хүүхдийн сан, ОУХБ, ОУШХБ-ын техникийн туслалцаатайгаар янз бүрийн насны хүн ам, нийгмийн бүлгүүдэд чиглэсэн олон төрлийн арга хэмжээг туршин хэрэгжүүлж байна. Нийгмийн хамгааллын бодлого хариуцсан үндэсний болон орон нутгийн эрх бүхий байгууллагуудын чадавхыг сайжруулж мэдлэг мэдээллийг


нэмэгдүүлэн хүртээмжтэй, тэгш шударга нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлснээр ядуурлыг бууруулахад чиглэсэн нийгмийн хамгааллын зорилтот арга хэмжээг үндсэн нэгжид хэрэгжүүлэх, үндэсний хэмжээний шийдвэр гаргах үйл явцад оролцох орон нутгийн засаг захиргааны болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны оролцоог нэмэгдүүллээ.

ЗОРИЛГО 2:


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:





НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, ХАМГИЙН ӨНДӨР 15 САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



САНХҮҮЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ЗОРИЛГООР 2017-2019



■ 2.2: Эрүүл мэнд ■ 2.3: Боловсрол ■ 2.5: Хүнс, тэжээл ■ 2.1: Ус, ариун цэвэр ■ 2.5: Нийгмийн хамгаалал

ЗОРИЛГО 2.1:



ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ, УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ТЭГШ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ИЛҮҮ ТААТАЙ ОРЧИН БҮРДСЭН, МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААТАЙ, НИЙГМИЙН УХАМСРААР ДЭМЖИГДСЭН УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ СОНГОГДСОН ХОТЫН ЗАХЫН ХОРООЛОЛ БОЛОН СУМДАД САЙЖРУУЛАХ

Ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх

Ундны ус, ариун цэврийн байгууламжийн хангамж, үйлчилгээний салбарын ерөнхий зохицуулалт болон үндэсний хөгжлийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах хүрээнд Ус, ариун цэврийн байгууламжийн хангамж, үйлчилгээний сүлжээг бэхжүүлж, улмаар хүн амыг баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах ТХЗ-ыг (ТХЗ-6) хэрэгжүүлэх үндэсний стратегийг ажил хэрэг болгох чиглэлээр холбогдох салбарын яамдад (ЭМЯ, БХТЯ, БСШУСЯ, ЭЗХЯ) НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлж байна. НҮБ-ын Дэлхийн ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ, ундны усны хангамжид хийх дүн шинжилгээ, үнэлгээ (GLAAS, 2018)-ний аргачлалын дагуу Монгол Улсын онцлогт нийцүүлж ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ, ундны усны хангамж, үйлчилгээний талаарх судалгааг олон салбарыг хамруулж явуулсан. Энэхүү судалгаагаар хүн амын ундны усны хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт өгсөн төдийгүй цаашид тус салбарын засаглал, санхүүжилт, Ундны ус, ариун цэврийн байгууламжийн хангамж, үйлчилгээний асуудлаарх салбар хоорондын ажлын хэсгийн үйл ажиллагааг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулсан. ДЭМБ-аас ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах үндэсний чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хэд хэдэн төслийг ЭМЯ, Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газартай хамтран хэрэгжүүлээ. Үүний үр дүнд Нийслэлийн хүн амын усан хангамжийн аюулгүй байдлыг хангах, ариун цэврийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах хөтөлбөрийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй нь хамт Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-аар батлуулсан.

Монгол Улсын Засгийн газар Ундны усны чанарын стандартыг ус хангамжийн аюулгүй байдлын үүднээс шинэчлэн боловсруулж, 2018 оны 6-р сард батлуулсан. Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хоёр аймгийн төвийн усан хангамжийн байгууллагуудад Усны аюулгүй байдлын төлөвлөгөө (WSP)-ний хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт шалгалт хийв. Жижиг суурин газруудын, тухайлбал, нийт 33 сумын Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтэд усны аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтнүүд ЭМЯ-тай хамтран хөндлөнгийн үнэлгээ хийсэн. Эдгээр үнэлгээний үр дүнгээс харахад Орон

нутгийн түвшинд ундны усны аюулгүй байдлыг сайжруулахын тулд мэдээлэл судалгаанд суурилсан шийдвэр гаргах шаардлагатай байна. Ялангуяа, ДЭМБ-аас Усны аюулгүй байдлын төлөвлөгөө (УАБТ/WSP)-г хот суурин газрын усан хангамжийн системд хэрэгжүүлж хэвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг суурьшлын жижиг нэгжүүдэд өргөжүүлэн нэвтрүүлж эхэлсэн. ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн эдгээр хөтөлбөрийн үр дүнд хууль эрх зүйн орчин бүрдэж, Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавх, түүний хөндлөнгийн хяналт бэхжиж, хүн амын усан хангамжийн аюулгүй байдлыг хангах, ариун цэврийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх суурь тавигдлаа.

Эдгээр амжилтыг бататгахын тулд Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон “Орчны эрүүлмэнд” үндэстний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу гурван аймагт (Баянхонгор, Говь-Алтай, Завхан) НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг даван туулах чадварыг бүрдүүлж чадахуйц Ундны ус, ариун цэврийн байгууламжийн талаарх төрийн бодлого, барилга байгууламжийн зураг төсөл, усны аюулгүй байдлын төлөвлөлт зэрэг асуудлаар нөлөөлөл сурталчилгаа, чадавх бэхжүүлэх зэрэг олон үйл ажиллагааг хэрэгжүүллээ. НҮБ-ын Хүүхдийн сан нь Усны үйлчилгээг зохицуулах үндэстний зөвлөлтэй нягт хамтран ажиллаж, усны үйлчилгээний үнэ тарифыг тогтоох шинэ аргачлалыг нэвтрүүлснээр гэр хорооллын иргэдийн хэрэглээний усны үнэ буурч, иргэд ундны усаа хямд үнээр авч хэрэглэх боломжийг бүрдүүлсэн. Тодруулбал, төсөл хэрэгжүүлэх дөрвөн бүсийн хоёрт нь буюу Говь-Алтай, Баянхонгор аймагт Ухаалаг системд шилжүүлсэн ус түгээх бичил цэгүүдийг байгуулахад НҮБ-ын Хүүхдийн сангаас техникийн туслалцаа үзүүлсэн. Ингэснээр ундны усны үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, ашиглалт, засвар үйлчилгээний өртөг зардал буурч байна. НҮБ-ын Хүүхдийн сангаас Говь-Алтай аймагт зориулж ус түгээх цэгийн сервер, тоног төхөөрөмжийн багц (техникийн хийгээд санхүүгийн хяналтын програм хангамж, хэрэглэгчдэд зориулсан 3,000 ширхэг ухаалаг карт) болон Түргэн үйлчилгээний ухаалаг системд шилжүүлсэн ус түгээх нэг цэгийн багц системийг үзүүлэн таниулах туршилт болгон санхүүжүүлсэн. Үүний үр дүнд Говь-Алтай аймгийн захиргаа аймгийн төвдөө нэмж 20 Түргэн үйлчилгээний ухаалаг системд шилжүүлсэн ус түгээх цэгүүдийг байгуулахаар санхүүжилтийг нь баталгаажуулж өгсөн. Ингэснээр аймгийн төвийн (Алтай хотын) нийт айл өрх 100 хувь (16000 иргэн) тогтмол ажиллагаатай Түргэн үйлчилгээний ухаалаг системд шилжүүлсэн ус түгээх 21 цэгээс хоногийн 24 цагийн туршид ундны усаар хангагдах боломж бүрдсэн. Үндэстний хэмжээнд эрх баригчид ч мөн ухаалаг системд шилжүүлсэн ус түгээх цэгийг орон даяар хэрэгжүүлэх талаар дэмжиж, сурталчилж эхэлсэн.

Цэцэрлэг, сургууль, дотуур байрны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ

НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр усан хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор Сургуулиудын түншлэлийн сүлжээг үүсгэн хамтран ажилласнаар цэцэрлэг, сургууль, дотуур байранд усан хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний үндэстний стандарт хэм хэмжээ, хэрэгцээ шаардлагыг мөрдөн хэрэгжүүлэх Боловсролын салбарын чадавхыг сайжруулж, засгийн газрын холбогдох байгууллагууд, үндэстний болон олон улсын ТББ-ууд, хувийн хэвшлийнхэн, хандивлагчид болон бусад түншүүд хамтран ажиллах нөхцөл бүрдсэн. НҮБ-ын Хүүхдийн сангийн шууд техникийн тусламжтайгаар хэрэгжүүлсэн усан хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ,


боловсрол, өсвөр үеийнхэн зэрэгт чиглэсэн хөтөлбөрүүдийн үр дүнд Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын стандартыг шинээр боловсруулж 2019 оны 8-р сард Монголын Стандарт хэмжил зүйн газраар батлуулсан. Түүнчлэн, сургууль, дотуур байр, цэцэрлэгийн усан хангамж, ариун цэврийн байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний талаар нөлөөлөл сурталчилгааны болон чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. Гурван аймгийн (Баянхонгор, Говь-Алтай, Завхан) алслагдсан сургууль, дотуур байр, цэцэрлэгүүдэд зориулсан уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг даван туулах чадвартай, шинэлэг усан хангамж, ариун цэврийн байгууламжийн зураг төсөл боловсруулах, турших зэрэг ажлууд хийгдэж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг даван туулах чадвартай усан хангамж, ариун цэврийн байгууламж гэдэгт усанд орох байр, гадаа жорлон, гүний усны худаг зэргийг хамруулж байгаа болно. Эдгээр байгууламжийн зураг төсөл, барилгын талбар (байршил)-ыг үер ус, хүчтэй салхи шуурга, хүйтний улирал зэрэг болзошгүй уур амьсгалын эрс өөрчлөлтийн эрсдэлд тэсвэртэй байх нөхцөлийг тооцож шийдвэрлэх юм.

Олон нийтийн оролцоо, хэлэлцүүлэг


НҮБ-ын Нутагшилт суурьшлын хөтөлбөрийн техникийн тусламжаар нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын бүст бие даасан, өрсөлдөх чадвартай, хүртээмжтэй дэд төвүүдийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын байгууллагуудын иргэдийнхээ оролцоог дэмжих, жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх чадавхыг бэхжүүлсэн. Бүтээн байгуулалтын үр шимийг хүртэгч хүн амын бүлгүүдтэй, тухайлбал, эмэгтэйчүүд, өндөр настнууд, тусгай хэрэгцээтэй хүмүүс, ойр орчны оршин суугч ард иргэд, айл өрхийн гишүүдийн төлөөлөлтэй нухацтай хэлэлцэж зөвлөлдсөний үндсэн дээр Нийслэл Улаанбаатар хотын дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөөний нарийвчилсан зураг төсөл, төлөвлөгөөг эцэслэн боловсрууллаа. Үүнд гэр хорооллын дэд төвүүдийн нутаг дэвсгэрт баригдах 11.06 км урттай усан хангамжийн сүлжээ, 18.55 км урттай бохир ус дамжуулах хоолой, дэд төвүүдээс гаднах нутаг дэвсгэрт баригдах 8.6 км урттай бохир ус дамжуулах хоолой барих, Баянхошуу, Сэлбэ орчмын дэд төвүүдэд тус бүрт нь 1000 шоо метр хүчин чадалтай усан сан байгуулах зэрэг төлөвлөгөө орсон болно. Дээрх зураг төсөл төлөвлөгөө болон тэдгээрийг хэрэгжүүлэх арга механизмыг тооцохдоо эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн хүн амын онцлог хэрэгцээг анхаарч ажиллаа.

ЗОРИЛГО 2.1 :


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД:

БСШУСЯ, ЭМЯ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Орон нутгийн захиргаад, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, АХБ

ЗОРИЛГО 2.2:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХИЙН ТУЛД ХОТ СУУРИН, ХОТЫН ЗАХЫН ХОРООЛОЛ БОЛОН ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ЯДУУ, ЭМЗЭГ ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ; ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ХҮН БҮР ТЭГШ ХАМРАГДАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ; НОТЛОГООНД СУУРИЛСАН БОДЛОГО, ШИЙДВЭР ГАРГАХАД ҮНДЭСНИЙХЭЭ БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХЫГ ДЭМЖИХ

НҮБ-ын системийн байгууллагуудын зохицуулалт сайтай нөлөөлөл сурталчилгаа, техникийн туслалцааны үр дүнд үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ядуу, эмзэг бүлгийн хүн ам тэгш хүртэх, ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн заалтууд тусгалаа олсон. Тухайлбал, Хүн амын эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд, Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, Халдварт бус өвчинтэй тэмцэх, Орчны эрүүл мэнд, Дархлаажуулалтын зэрэг үндэсний хөтөлбөрүүдийг дурдаж болно.

Бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор төлөвлөлт, төсөвлөлт, хяналт шинжилгээний чиглэлээр чадавхыг хөгжүүлэх замаар үндэсний болон орон нутгийн түвшинд институцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Орон нутгийн түвшинд чадавх, үүрэг хариуцлага нэмэгдсэний сацуу НҮБ-ын системийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газар олон улсын хэд хэдэн чуулган зохион байгуулж “Сүрьеэг устгах Улаанбаатарын тунхаг”, “Цэвэр агаарын төлөөх Улаанбаатарын Уриалга” зэрэг баримт бичгүүдийг чуулганд оролцсон улс орнуудын төлөөлөгчдийн хамтаар хэлэлцэн баталсан.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр зорилтот төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийг эрт илрүүлэх, эмнэлэг эмчилгээг өргөжүүлэн тэлэх, хөдөлгөөнт-эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, телемедицин зэрэг тусламж үйлчилгээний шинэлэг загваруудыг хэрэгжүүлэх, эх, нярай, хүүхдийн эрүүл мэндийн нэгдсэн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг томоохон ахиц гарч байна. Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА/IAEA)-аас Монгол Улсын цөмийн анагаах ухааны хэрэглээ, чанарыг сайжруулах чиглэлээр үзүүлж байгаа дэмжлэгийн үр дүнд анагаах ухааны салбарт радио-иммуно-ассей технологи, шинэлэг журам горимыг нэвтрүүлж, хүний нөөцийг бэхжүүлснээр оношилгооны нарийвчлал, чанар эрс сайжирлаа.

НҮБ болон АХБ-ны хамтарсан нөлөөлөл сурталчилгааны ажлууд нь 2019 оны улсын төсөвт жирэмслэлтээс хамгаалах эм хэрэгсэл, бичил тэжээлийн хангамж зэрэг нийгмийн эрүүл мэндийн зардлын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн. 2019 онд жирэмслэлтээс хамгаалах эм хэрэгсэлд 1.8 тэрбум төгрөг зарцуулсан нь 2018 оныхоос 12 дахин их байгаа юм.

Хамгийн гол нь санхүүжилтийг тогтвортой болгож, жирэмслэлтээс хамгаалах эм хэрэгсэл, бичил тэжээлийн хангамжийн 2020 оны төсөв дээр Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас 300 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламжийг зайнаас тэгш хүртээмжтэй, хугацаа алдахгүй шуурхай хүргэх зорилгоор байгуулсан телемедициний сүлжээг улсын хэмжээнд өргөжүүлэн тэлж алслагдсан дүүргүүд, нийслэлийн гурван амаржих газрыг холболоо. Телемедицины төслийн хүрээнд орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэж, зайнаас зөвлөгөө өгөх, авахад баримтлах журам стандарт, симуляцийн лабораторийн ашиглалт, зайнаас зөвлөгөө өгөх, авах байгууллагын ажиллах журам, хүлээх үүргийн талаарх заавар журмыг боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/386 болон А/385 тоот тушаалаар тус тус баталсан⁷. Орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрх үүрэг бүхий мэргэжилтнүүд үндэсний хэмжээний зөвлөхүүдтэй цахимаар шууд харилцаж шаардлагатай зөвлөгөөг авах боломж бүрдсэн. Эмч, эх баригч, сувилагч нарын эрүүл мэндийн мэргэжлийн боловсролыг тасралтгүй дэмжих зорилгоор улсын хэмжээнд эмнэлгийн болон эрдэм шинжилгээний байгууллагуудыг 0.8 сая амдолларын өртөг бүхий Эх барих, нярайн яаралтай тусламжийн сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан.

Улаанбурхан өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтын аяныг зохион байгуулах шаардлагатай байгаа талаар Монгол Улсын Засгийн газраас хүсэлт ирүүлсний дагуу НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ-аас санхүүгийн хийгээд техникийн шуурхай туслалцаа (500 мянган ам.доллар) үзүүлсний үр дүнд өмнө нь дархлаажуулалтад хамрагдаагүй байсан 450 мянган хүүхдийг дархлаажуулалтад хамруулсан. Бүс нутгийн нөхцөл байдлаас үл хамааран Монгол Улсад улаанбурханы өвчлөл, эндэгдлийн баталгаажсан тохиолдол бүртгэгдээгүй болно.

Дээрх олон хүчин чармайлт гарч байгаа хэдий ч 2018 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны (2019 онд хэвлэж тараасан) үр дүн хүн амын эрүүл мэндийн гол үзүүлэлтүүдэд дорвитой өөрчлөлт гараагүй байгааг илэрхийлж байна. Эрүүл мэндийн зайлшгүй тусламж үйлчилгээний багцын хамрагдалт 2018 онд 63 хувьтай байна. Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин тогтвортой биш байгаа хэдий ч хүн амын дундаж наслалт улсын хэмжээнд уртасч, хүний амь насыг хамгаалах шинэ шинэ вакциныг нэвтрүүлж байгаатай холбоотойгоор




урьдчилан сэргийлж болохуйц өвчний дархлаажуулалтын хамрагдалт сайжирч, тэмбүүгийн илрүүлэлт 38 хувиар нэмэгдэж, эрүүл мэндийн даатгалтай хүн амын 1/3 нь гепатитын халдвар авсан эсэх талаараа мэдлэгтэй болж эмчилгээ хийлгэх боломжтой болсон.


⁷ <https://www.mohs.mn/uploads/files/8847efe5f4d9cd7dd2650edc21f5c7d0d53d126a.pdf>
<https://www.mohs.mn/uploads/files/74011a8711d550c99476100d34ef40b90e03fb4d.pdf>

ЗОРИЛГО 2.2:


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, ХАМГИЙН ӨНДӨР 10 САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД:

Монгол Улсын Их хурал, СЯ, ХНХЯ, ЭМЯ, Орон нутгийн захиргаад, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хүний эрхийн үндэсний зөвлөл, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Улсын төв нэгдүгээр эмнэлэгийн Цөмийн оношлогооны тасаг, Монгол Улсын Шинэ нийгмийн эрүүл мэндийн холбоо, Монголын хүүхдийн эмч нарын холбоо, АШУҮИС.

ЗОРИЛГО 2.3:



ИЛҮҮ ЧАНАРТАЙ СУУРЬ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИЖ, ХҮҮХДИЙГ БАГА НАСНААС НЬ ХӨГЖҮҮЛЭХ, УЛМААР НАСАН ТУРШ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НӨХЦӨЛ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ХӨТӨЛБӨРИЙГ ХОТЫН ЗАХЫН ХОРООЛЛЫН СОНГОГДСОН ХЭСГҮҮД, ЗАРИМ СУМДАД ХЭРЭГЖҮҮЛЭХ



Боловсролын талаарх бодлого, төлөвлөлт, Чанартай боловсролыг дэмжих ТХЗ 4-ийг нутагшуулах

Өнөөгийн НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээг хэрэгжүүлж эхэлсэн тэр мөчөөс мэдлэг боловсролыг дэмжих, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, боловсролын салбарын төлөвлөлт, бодлогын дүн шинжилгээ хийх үндэсний чадавхыг хөгжүүлэх, ТХЗ 4-ийг нутагшуулах улмаар ТХЗ 4-ийн зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийг боловсролын хөгжлийн тэргүүлэх чиглэл, төлөвлөгөөтэй уялдуулах зэрэг чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэхэд гол анхаарлаа чиглүүлж ирсэн. НҮБ-ын техникийн хийгээд санхүүгийн дэмжлэгтэйгээр хэд хэдэн сэдэвчилсэн судалгаа, үнэлгээг хийгээд байна. Тухайлбал, Боловсролын салбарын бодлогын үнэлгээ, ESIS үнэлгээ, Уур амьсгалын өөрчлөлтөөс боловсролд үзүүлэх үр нөлөө, Хүртээмжтэй боловсролын хөтөлбөрийн үнэлгээ, Эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийн судалгаа, Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (ОУБТС/MICS), Глобал сургалт ба тэгш байдлыг хангах боловсролын шинжилгээ (EAGLE) Educational Analysis for Global Learning and Equity (EAGLE) зэрэг болно.

Эдгээр судалгааны гол үр дүн, зөвлөмжийг 2021-2030 онд хэрэгжүүлэх Боловсролын салбарын мастер төлөвлөгөө (БСМТ/ESMP)-г боловсруулахад ашигласан бөгөөд боловсролын хүртээмж, тэгш байдлыг хангах талаарх тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход үнэтэй хувь нэмэр оруулсан. Боловсролын салбарын мастер төлөвлөгөөг боловсруулах ажлыг БСШУСЯ хөгжлийн түншүүдийн идэвхтэй оролцоотойгоор удирдаж байгаа бөгөөд энэхүү төслийг АХБ-ны дэмжлэгтэйгээр НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн банк, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага зэрэг байгууллагууд хамтран хэрэгжүүлж байна. Боловсролын салбарын мастер төлөвлөгөө нь ойрын арван жилд боловсролын салбарыг удирдан чиглүүлэх стратеги баримт бичиг бөгөөд бүх хүмүүст хүртээмжтэй, тэгш, чанартай боловсролын үйлчилгээг хүргэх чиглэлийг тогтооход чухал үүрэг гүйцэтгэнэ.

ХНХЯ, БСШУСЯ хамтран техникийн боловсрол, мэргэжлийн сургалт, ур чадвар олгох сургалтын чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоотойгоор анхны үндэсний чуулганыг зохион байгуулж хөдөлмөрийн



зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын шинэчлэлийг хийх, чанарыг сайжруулах, санхүүжилтийг баталгаажуулах талаар чухал зөвлөмжүүдийг гаргасан. Түүнчлэн багш нарын мэдээлэл харилцааны технологийн чадамжийн стандартыг 2019 онд боловсруулж, Засгийн газраас багш нарт мэдээлэл харилцааны технологийн суурь чадамжийг заавал эзэмшүүлэх бодлогын хэрэгсэл болгон баталсан.

Дээд боловсрол

Дээд боловсролыг дэмжих зорилгоор Боловсролын магадлан итгэмжлэх үндэстний зөвлөл болон БСШУСЯ-нд НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлж байна. Бодлого боловсруулах, магадлан итгэмжлэл авах, дээд боловсролын чанар, стандартыг дээшлүүлэх, мэдээлэл харилцаа технологийг нэвтрүүлэх, нээлттэй, зайны сургалт явуулах, тогтвортой хөгжлийн боловсрол, чадавх хөгжүүлэх зэрэг чиглэлээр дээд боловсролын асуудал эрхэлсэн дээрх байгууллагуудын чадавхыг сайжруулсан. Монгол Улс нь Дээд боловсролын эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Ази, Номхон далайн бүс нутгийн 2011 оны Конвенцийг соёрхон баталж, бусад улс оронд болон Монгол Улсад олгож байгаа дээд мэргэжлийн талаарх мэдээллийг цуглуулж боловсруулах Үндэстний мэдээллийн төвийг Боловсролын магадлан итгэмжлэх үндэстний зөвлөлийн дэргэд байгуулахаар төлөвлөж байна.

Тэгш, хүртээмжтэй, аюул эрсдэлгүй сургуулийн орчин

Тасралтгүй үргэлжлүүлж байсан нөлөөлөл, сурталчилгааны ажлын үр дүнд хүртээмжтэй боловсролын үйлчилгээг хүн амд хүргэх бодлогын орчин сайжирч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургуульд боловсрол эзэмшүүлэх талаарх холбогдох хууль тогтоомжийг баталсны зэрэгцээ эцэг эхчүүд, хүн амын бүлгүүдийг сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Олон төрлийн сургалт, уулзалтууд зохион байгуулснаар




хүн амын дунд хүртээмжтэй боловсролын талаарх ойлголтыг сайжруулж эерэг хандлагыг бүрдүүлж өгсөн. Үүний үр дүнд төсөл хэрэгжүүлж байгаа аймгуудын Хүүхдийн хөгжлийн хоёр төвд бүтэн цагаар ажиллуулах багшийн орон тоог батлуулж чадсан нь тухайн орон нутгийн захиргаадын зүгээс үзүүлсэн томоохон дэмжлэг хийгээд амжилт юм. Түүнчлэн, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр байгуулсан Хүүхдийн хөгжлийн төв (ХХТ/CDC) нь бие даасан, хүүхдэд ээлтэй орчинтой, тэр дундаа институцийн түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжсэн амжилттай загвар болж чадсаныг БСШУСЯ хүлээн зөвшөөрсөн билээ. БСШУСЯ-ны зүгээс энэ загварыг бусад аймгуудад хэрэгжүүлэх зорилгоор Дэлхийн Банкны холбогдох талуудтай хэлэлцэж байгаа болно. Мөн сургуулийн орчны аюулгүй байдлын стандарт, дотуур байрны стандартыг баталсан бөгөөд 2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Бага насны хүүхдийн хөгжил


Сургалт, нөлөөлөл сурталчилгааны олон ажлаар дамжуулан бага насны хүүхдийн цогц хөгжлийн чиглэлээр орон нутгийн хэмжээнд олон салбарын хамтын ажиллагаа, чадавхыг бэхжүүлсэн нь салбаруудын төлөөллийг хамруулсан Ажлын хэсгийг байгуулж, Бага насны хүүхдийг хөгжүүлэх нэгдсэн стратегийг боловсруулах боломжийг бүрдүүллээ. Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох орчныг бүрдүүлэхэд тулгарч байсан сорилт бэрхшээлийг шийдвэрлэхдээ дотоод орчны агаарын чанарыг сайжруулах, зорилтот бүсүүдэд усан хангамж, ариун цэврийн байгууламжийг сайжруулах арга хэмжээг авснаар бага насны хүүхдийн боловсролын төвүүдийн дэд бүтэц орчин нөхцөл сайжирсан. Яамны түвшинд болон эцэг, эхийн дунд 24 цагийн цэцэрлэгийн үйлчилгээнд хүүхэд хамгаалал, хоол тэжээл, боловсрол зэрэг салбар хоорондын хамтын ажиллагаа нэн чухал шаардлагатай болох талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлсэн.

ЗОРИЛГО 2.3:


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД: БСШУСЯ, АХБ

ЗОРИЛГО 2.4:



НИЙТ ХҮН АМЫГ, ЯЛАНГУЯА, ЯДУУ, ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮН АМЫГ ТҮЛХҮҮ ХАМРУУЛСАН ҮР АШИГТАЙ, ҮР НӨЛӨӨТЭЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ

Нийгмийн хамгааллыг бэхжүүлэх

Монгол Улс дахь НҮБ нь нийгмийн хамгааллын бодлого, хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, хөдөлмөр эрхлэгчдийг хамгаалсан, тэгш шударга нийгмийн хамгааллын тогтолцоог хөгжүүлэх үүрэг хариуцлага хүлээсэн үндэстний болон орон нутгийн байгууллагуудын чадавх, ойлголт мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд ядуурлыг бууруулахад чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг үндсэн нэгжид хүрч хэрэгжүүлэх талаарх өргөн хүрээний яриа хэлэлцүүлэг өрнүүлж орон нутгийн удирдлагуудын дуу хоолойг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) болон үндэстний түвшний шийдвэр гаргагчдад хүргэх нөхцөл бүрдсэн. Нөлөөлөл сурталчилгааны үйл ажиллагааны хүрээнд, “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гарсан сургамж, бодит жишээнд тулгуурлан нийгмийн хамгааллын мөн чанар, хүн амын бүлгүүдийн хамгааллын гадна орхигдох эрсдэл, ялгаварлал, хүн амын орлогын аюулгүй байдал, хүний эрх зэрэг асуудлын талаарх мэдээллийг бодлого боловсруулагчдад хүргэж ажиллаа. НҮБ-ын дэмжлэгтэйгээр Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт хэм хэмжээг тогтоож үйл ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлсэн нь хөтөлбөрт оролцогч засгийн газар, ажил олгогч, ажилчдын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд тус болсон.


Нийгмийн хамгааллын өнөөгийн тогтолцоонд тулгарч буй сорилт бэрхшээлийг шийдвэрлэх, улмаар гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэх нь НҮБ-аас үзүүлэх дэмжлэг туслалцааны тэргүүлэх чиглэлийн нэг байлаа. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран гамшгийн эрсдэлийг даван туулахад чиглэсэн нийгмийн хамгааллын туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлж зудын гамшигт нэрвэгдсэн сумдын айл өрхүүдэд өвлийн онцгой нөхцөлийн бэлэн байдлыг хангах, улмаар эрсдэлийг даван туулахад нь зориулж туслалцаа үзүүлсэн. Малчдын хүүхдүүдийг өвлийн дулаан хувцас, сургуулийн шаардлагатай зарим хэрэгслээр хангах, айл өрхүүдэд хоол хүнс худалдан авахад зориулан мөнгөн тусламж үзүүлээ. Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалж удаан хугацаанд үргэлжилж мэдэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гамшгийн эрсдэл өндөртэй Завхан аймгийн дөрвөн сумын (Их-Уул, Тосонцэнгэл, Баянтэс, Тэс сум) 0-5 насны нийт 2,729 хүүхдэд өнөөгийн хэрэгжиж байгаа Хүүхдийн мөнгөний хөтөлбөр дээр нэмэлт болгон мөнгөн тэтгэмж үзүүлсэн. Гамшгийн эрсдэл өндөртэй сумдын малчдын хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааг аль болох эрт, цаг алдалгүй авч хэрэгжүүлэх аваас гамшигтай тэмцэх өнөөгийн тогтолцоо




хамгийн бага зардлаар үр дүнтэй ажиллах боломжтойг туршилтын хөтөлбөр харуулсан. Туршилтын дараагийн шатанд буюу зудад нэрвэгдсэн сумдын малчин айл өрхүүдийн хүүхдүүдийн наад захын хэрэгцээг цаг алдалгүй хангасны дараа туршилтын хөтөлбөрийн үр нөлөөний шуурхай үнэлгээг хийнэ. Гамшгийн үеийн нийгмийн хамгааллын чиглэлээр ажилладаг Хөгжлийн түншүүд болон Олон улсын төрийн бус байгууллагууд хоорондын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр НҮБ-ын Хүүхдийн сангаас ихээхэн хүчин чармайлт гаргаж Монгол Улсын Засгийн газартай хамтран хөгжлийн түншүүдэд зориулсан томоохон хэмжээний уулзалт семинар зохион байгуулж Дэлхийн хүнсний байгууллага, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа танилцуулж, АХБ, ХХААБ, НҮБХХ, Дэлхийн зөн, Хүүхдийг ивээх сан, Улаан загалмайн байгууллага зэрэг бусад олон улсын байгууллагууд идэвхтэй оролцсон. Туршилтын хөтөлбөрийг “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, гамшгаас хамгаалах, бэлэн байдлыг хангах” НҮБ-ын хамтарсан хөтөлбөрийн хүрээнд өргөжүүлэн тэлж 2020-2021 онуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

ЗОРИЛГО 2.4:


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД:

ХНХЯ, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо

ЗОРИЛГО 2.5:



ХҮНС БОЛОН ХООЛ ТЭЖЭЭЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ (ЭРҮҮЛ ХҮНС/ТЭЖЭЭЛИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ, ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ДУТЛЫН ЭРСДЭЛИЙГ ЭРС БУУРУУЛАХ, ХҮНС, ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ТАНДАН СУДАЛГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ)

НҮБ нь хүнсний аюулгүй, баталгаатай байдлыг хангах, хүн амын хамгийн эмзэг бүлгийн нэг болох хүүхдийн хоол тэжээлийн асуудлыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлж ирсэн. НҮБ-ын Хүүхдийн сангаас Хүүхдэд ээлтэй эмнэлгийн санаачилгын (BFHI) хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Эмнэлгийн магадлан итгэмжлэлийн хөтөлбөртэй уялдууллаа. Баяжуулсан буудайн гурилын стандарт, премиксийн найрлагын стандартыг батлав. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль (АШУҮИС) нь тэжээх ухааны мэргэжилтэн, хоол судлаачийн бакалаврын зэрэг олгох сургалтын анхны хөтөлбөрийг 2019 оноос хэрэгжүүлж эхлээд байна. Эрүүл мэндийн боловсролын тухай сурах бичгийг боловсруулан гаргаж ерөнхий боловсролын сургуулийн 4-12-р ангийн сурагчдад хүргэхээр орон даяар түгээсэн болно. Цэцэрлэг, сургуулиудад халуун хоолоор үйлчлэх хүчин чадал бүхий хоол үйлдвэрлэлийн цэгүүдийг загвар болгон байгуулсан. Хоол тэжээлийн нэгдсэн багц үйлчилгээнд тав хүртэлх насны 35,300 гаруй хүүхэд хамрагдлаа.

НҮБ-ын техникийн тусламжтайгаар хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эрх зүйн орчин, аюулгүй байдалд үнэлгээ хийж үр дүнг Таримал ургамлын сортын эрхийг хамгаалах олон улсын конвенцид нийцүүлэн Таримал ургамлын үр, сортыг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад ашигласан бөгөөд хуулийн төслийг УИХ-д батлуулахаар өргөн бариад байна. Энэхүү хуулийг батлуулснаар ургамлын төрөл зүйлийг хамгаалахын (Ургамалын үр сорт үржүүлэгчдийн эрх) зэрэгцээ, шинээр болон сайжруулсан ургамлын үр сортуудыг бий болгож улс орны хүнсний аюулгүй байдлын индексийг сайжруулахад түлхэц болно. Жимс жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг (GAP) хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар 2019 оны 5-р сард баталсан. Энэхүү зааврыг мөрдсөнөөр байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлын дадлыг нэвтрүүлж төлөвшүүлэх юм. Хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлсэн гэрчилгээтэй болгосноор хэрэглэгчид бүтээгдэхүүний сонголтоо зөв хийж, аж ахуй эрхлэгчид ч үр ашигтай бизнес эрхлэх боломж бүрдэнэ. Хүн амын жимс жимсгэний хэрэглээ бага байгаатай холбогдуулан орон нутгийн жимс жимсгэний үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлага их байгаа учир жимс, жимсгэний үндэсний стратегийг боловсруулсан.

НҮБ-ын ХХААБ, Олон улсын цахилгаан холбооны бүсийн албадын дэмжлэгтэйгээр Цахим хөдөө аж ахуйн үндэсний стратегийг боловсруулсан нь тус улсын хөдөө аж ахуйн салбарт мэдээлэл, харилцааны технологийг шинэ түвшинд хүргэж үйлдвэрлэлийн бүтээмж, аж ахуй эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжийг тэлж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хэмжээнд малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийсэн нь төрөл зүйлүүдийн үүлдэр, омгийн төлөв байдлыг байршил, зах зээлийн үнэлгээгээр нь тодорхойлох боломжийг бүрдүүлсний зэрэгцээ стратеги төлөвлөлтийн дагуу цаашид авах арга хэмжээний шийдвэр гаргахад түлхэц өгсөн. Энэхүү үнэлгээний үр дүнг Мал үржүүлэг, үйлдвэрлэлийн мэргэжилтнүүдийн үндэсний зөвлөгөөнд танилцуулсан. Хил дамнасан мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратеги (2020-2023) боловсруулсан нь малын ашиг шимийг нэмэгдүүлэх, монгол малчдын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүн амыг аюулгүй, эрүүл хүнсээр хангах, малын гаралтай бүтээгдэхүүний (мах, ноолуур) экспортыг дэмжих талаарх төрийн бодлыг хэрэгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА/IAEA)-ийн техник, технологийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн (УМЭАЦТЛ/SCVL) малын эмийн үлдэгдэл, химийн бохирдлыг шинжлэн хяналт тавих мэргэжлийн чадавхыг дээшлүүлсэн. Монгол Улс одоогоор дотоодын болон импортын бүтээгдэхүүний аль алинд малын эмийн үлдэгдэл, химийн бохирдлын шинжилгээ хийж байгаа бөгөөд цаашид Европын холбооны экспортын шаардлагыг хангах зорилгоор хүчин чадлаа өргөжүүлэхээр төлөвлөж байна. Энэ нь тус улсын хүнсний аюулгүй байдалд эерэг нөлөө үзүүлж байгаа төдийгүй Монгол Улсаас гуравдагч орнуудад хүнсний бүтээгдэхүүний экспортын жилийн өсөлтийг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна. Лабораторийн эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, сорилт баталгаажуулалтын хамрах хүрээ улам тэлж байгаагийн зэрэгцээ экспорт, импортын малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд антибиотикийн үлдэгдэл, пестицид, меламиний бохирдлын шинжилгээг нийт 2561 сорьцонд хийгээд байна.


Мал эмнэлгийн хүрээлэн нь орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр тоноглогдсон учир малын гоц халдварт өвчин хил дамжин тархахаас сэргийлэх, түргэвчилсэн оношилгоо хийх, хортон шавж, өвчин үүсгэгчийг устгах (PPR), Африкийн гахайн халуурал (ASF) өвчний халдварын дэгдэлтийг таслан зогсоох чиглэлээр чадавхыг бэхжүүлээд байна. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын тууштай дэмжлэгтэйгээр Биокомбинатын вакцины цехэд вакцин үйлдвэрлэл, савлагаа, таг бөглөө лацны шугам суурилуулж, гар, хөл, амны өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг үйлдвэрлэхэд бэлэн болгосон. Үндэсний болон орон нутгийн хүний нөөцийг бэлтгэж өвчин оношлох, хянах чиглэлээр өргөн хэмжээний сургалтанд хамруулсан.

ЗОРИЛГО 2.5:


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭ



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД:

ХХААХҮЯ, БСШУСЯ, ЭМЯ, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэстний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэстний төв, Ургамал, газар тариалангийн шинжлэх ухааны хүрээлэн, Мал эмнэлэгийн хүрээлэн, Хөдөө аж ахуйн их сургууль

ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ ГУРАВ:



ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИЖ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ



ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ:

2021 ОН ГЭХЭД ЗАСАГЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД НЬ ЗАЛУУЧУУДЫН ИДЭВХТЭЙ ОРОЛЦООГ ДЭМЖИЖ, ЯДУУ, ЭМЗЭГ БҮЛГИЙНХНИЙ БОЛОН ХҮН БҮРИЙН ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛЖ АРД ИРГЭДИЙНХЭЭ ӨМНӨ ИЛҮҮ НЭЭЛТТЭЙ БАЙЖ, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГАА ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙНА

Энэхүү үр дүнгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны гол зорилго нь “хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх”, улс орны хөгжлийн үр шим хүн бүрт, ялангуяа залуучууд, ядуу, эмзэг бүлгийн хүн амд өгөөжтэй байх нөхцөлийг хангах үүрэг бүхий засаг захиргааны байгууллагуудын чадавхыг сайжруулахад чиглэсэн. Энэ хүрээнд НҮБ-ын системийн 7 байгууллага нийтдээ 20.9 сая ам.долларын хөрөнгийн санхүүжилтийг босгосон бөгөөд үүнээс 13.38 сая ам.долларын хөрөнгийг хэрэгжүүлэгч 23 байгууллагатай хамтран 9 аймаг, нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн 17 төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд зарцуулсан. Нийт хөрөнгийн зарцуулалтын дийлэнх хувийг ТХЗ 16 – Энх тайван, шударга ёсыг цогцлоох, ТЗХ 5 – Жендерийн эрх тэгш байдлыг хангах, ТХЗ 3 – Эрүүл мэндийг дэмжих, ТЗХ 17 – Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зэрэг дөрвөн ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулсан болно.

Үндсэн хуулийн үнэлгээ

Хувьсан өрнөх улс төрийн яриа хэлцлийн бодит үр дүнг үйл хэрэг болгох зорилго агуулж Монгол Улсын үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийх үйл ажиллагаанд өнгөрсөн жилүүдэд НҮБ-аас дэмжлэг үзүүлж ирсэн. Түүнчлэн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үйл явцыг дэмжих стратегийг боловсруулж орон нутгийн удирдлагын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга замыг дараах асуудалд чиглүүлэх боломж нээгдсэн. Тухайлбал, а). нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад шаардагдах мэдээллийн бааз бий болгох, б). орон нутгийн удирдлага нь өөрсдийн хийсэн дүн шинжилгээ, мэдлэг туршлагаа хуваалцах замаар шийдвэр гаргах үйл явцад оролцох, с). мэргэжлийн болон шинжээчдийн дүгнэлтийг гаргах зорилгоор мэргэжилтнүүдийн мэдлэг туршлагыг ашиглах зэрэг болно. Үүний үр дүнд Үндсэн хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2019 оны 11-р сард УИХ-аар баталсан.

Хууль эрх зүйн хамгааллын механизм

Сүүлийн хоёр жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газар, НҮБ хамтран тус улсын хууль эрх зүйн хамгааллын механизмыг боловсронгуй болгох чиглэлээр томоохон алхам хийсэн. НҮБ-ын дэмжлэгтэйгээр Залуучуудын хөгжлийн тухай хуулийг боловсруулж баталлаа. Түүнчлэн, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль зэрэг хуулиудын шинэчилсэн найруулгыг боловсруулж, батлуулах ажилд НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт техникийн туслалцаа үзүүлээ. Мөн Хөдөлмөрийн тухай хууль, Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж, батлуулахаар УИХ-д өргөн барьсан. Түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан болно. 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн боловсруулахад ХНХЯ, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбоо зэрэгт НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлсэн.

Залуучуудын хөгжлийн төвүүд

Үндэсний хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг НҮБ-аас дэмжиж ажиллаа. Тухайлбал, 2012 онд батлагдсан Монгол Улсын Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. НҮБ-аас Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажилласнаар Засгийн газрын санхүүжилттэйгээр Залуучуудын хөгжлийн 16 төвийг 2016 онд байгуулж байсан бол энэ нь 2019 онд 33 болж 2 дахин нэмэгдлээ. Эдгээр төвүүдэд залуучуудын чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн амьдрах ухаан, бэлгийн болон нөхөн үржихүйн боловсрол мэдлэг олгох зэрэг олон төрлийн сургалт, үйл ажиллагааг явуулж байна.

Мэдээлэл судалгааг хөгжүүлэх


НҮБ нь 2018 онд явуулсан үндэсний хэмжээний анхны Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа зэрэг үндэсний хэмжээний томоохон судалгаа явуулах, тэдгээрийн үр дүнг баталгаажуулахад мэргэжлийн хийгээд санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсний зэрэгцээ жендэрт суурилсан/гэр бүлийн хүчирхийллийн талаарх захиргааны

статистикийн тогтолцоог бий болгох, илүү боловсронгуй болгоход Засгийн газарт дэмжлэг үзүүлсэн хэвээр байна. НҮБ-аас Завхан, Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран өсвөр насныхан болон залуучуудын дунд тэдний сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой асуудлаар судалгаа явуулсан. Түүнчлэн 2018 онд тус улсын хүн амын дунд жендэрт суурилсан хүчирхийллийн бодит нөхцөл байдлыг судлах зорилгоор ҮСХ-той хамтран Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ/GBV) -ийн үндэсний хэмжээний судалгааг анх удаа явуулж, үр дүнг хэвлэн нийтэлсэн нь тус улсын ЖСХ-ийн тархалтын бодит нөхцөл байдлыг харуулж чадсан юм. 2017 онд Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК)-оос НҮБ, Европын Холбоотой хамтран Монгол Улсад худалдаа, үйлчилгээ, ноос, ноолуурын үйлдвэрлэл эрхэлж байгаа жижиг, дунд үйлдвэрүүдэд хүний хөдөлмөрлөх эрхийг хэрхэн хамгаалж байгаад судалгаа хийсэн⁸. Судалгааны үр дүн, зөвлөмжийг ХЭҮК-оос жил бүр эрхлэн гаргадаг Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх 16 дугаар тайланд тусгаж, УИХ-д өргөн барьсан.


⁸ <https://bit.ly/2LcSAqR>

ЗОРИЛГО 3:

НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, ХАМГИЙН ӨНДӨР 16 САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР





НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



САНХҮҮЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ЗОРИЛГООР 2017-2019



■ 3.1: Хамгааллын механизм.. ■ 3.3: Залуучуудын сүлжээ .. ■ 3.2: Оролцоо ..

ЗОРИЛГО 3.1:



ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ЯЛАНГУЯА, ЯДУУ, ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮН АМЫГ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛЭЭС ХАМГААЛАХ ЗОРИЛГООР ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙЖ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ХӨГЖҮҮЛЭХ ЗАМААР ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛЛЫН МЕХАНИЗМЫГ САЙЖРУУЛАХ

Энэхүү үр дүнгийн хүрээнд ядуу, эмзэг бүлгийн хүн амын оролцоог дэмжих, засгийн газрын хариуцлагыг бэхжүүлэх хууль эрх зүйн хамгааллын механизмыг боловсронгуй болгох зорилго тавьсан болно. Тайлангийн хугацаанд НҮБ-аас эмэгтэйчүүд, охид, хүүхдүүд, хөдөлмөр эрхлэгчид, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хамгааллын орчныг бэхжүүлэхэд чиглэсэн нөлөөлөл сурталчилгааны үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, салбар хоорондын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах, эдгээр хүний эрхийг хамгаалах үйлчилгээнд зориулсан улсын төсвийн хуваарилалтыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллалаа. Түүнчлэн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улмаар тэмцэх механизмыг бэхжүүлэх, үүрэг хүлээгч талуудын чадавхыг бэхжүүлж эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөдөлмөр эрхлэгчид болон бусад эмзэг бүлгийн хүмүүсийн эрхийг хамгаалж, баталгаажуулах талаарх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас дэмжлэг тусалцаа үзүүлсэн.

Жендерийн тэгш байдлыг дэмжих

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиудыг баталж хэрэгжүүлэх талаар НҮБ нь Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажиллаж байна. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн (CEDAW) хорооны зөвлөмжийг орон нутгийн засаг захиргааны Ажлын гүйцэтгэлийн гэрээнд тусгаж хариуцлага хийгээд төрийн болон төрийн бус байгууллагуудын салбар хоорондын хамтын ажиллагааг ханган ажиллаж байна. 2017 оноос хойш хэрэгжиж ирсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (ГБХТХ/LCDV) нь гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцож, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэгчдэд хариуцлага тооцох механизм үйлчлэх болсон. Үүний үр дүнд хохирогчийг хамгаалах механизм, бүтцийг орон даяар бий болгосны хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зохицуулах зөвлөл, орон нутгийн 30 Зохицуулах зөвлөл, олон талын төлөөлөл орсон 609 хамтарсан баг, Нэг цэгийн үйлчилгээний төвүүд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан хамгаалах байрууд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах

Хөдөлмөр эрхлэгчдийн эрх ашгийг илүүтэй дэмжсэн, олон улсын хэм хэмжээнд нийцсэн Хөдөлмөрийн тухай хуулийн төслийг боловсруулах, батлуулах чиглэлээр НҮБ нь Монгол Улсын Засгийн газар, нийгмийн түншүүдтэйгээ нягт хамтран ажиллаа. Түүнчлэн одоогоор хэлэлцүүлгийн шатанд буй Хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөний тухай хуулийн төсөлд мэргэжлийн зөвлөмж өгсөн. ОУХБ-ын конвенц, зөвлөмжийг хэрэгжүүлэх гурван талт механизмын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр засгийн газар, ажил олгогч эздийн болон ажилчдын байгууллагуудыг НҮБ-аас дэмжин ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэгчдийн эрхийг хүндэтгэн хамгаалах, ялангуяа албан болон албан бус эдийн засгийн аль алинд нь албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эрхийг хамгаалахад онцгой анхаарал хандуулж техникийн туслалцаа үзүүлэх, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэгээ үргэлжлүүлж байна.

Хүн худалдаалахтай тэмцэх

НҮБ нь Хүн худалдаалахтай тэмцэх талаар Монгол Улсын явуулж буй үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах зорилгоор 2012 онд батлагдсан Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлж байна. 2018 онд НҮБ-аас тус хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, үр дүнд нь үндэслэн хуулийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн удирдамж боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаарх улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хохирогчид болон гэмт хэргийн сүлжээг олж тогтоох механизмыг бий болгож хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах арга хэмжээг сайжруулах, Хүн худалдаалахтай тэмцдэг ТББ-уудын сүлжээг идэвхжүүлэх замаар төрийн болон иргэний нийгэм хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг зорилго агуулан 2019 онд өндөр түвшний хэлэлцүүлэг өрнүүлэхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбогдуулан, Албадан хөдөлмөрийг устгах тухай конвенцийн 2014 оны нэмэлт Протоколыг соёрхон баталж хэрэгжүүлэх, албадан хөдөлмөр эрхлүүлэх зорилгоор хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээ авах, хохирогчдыг дорвитой хамгаалж тэдэнд зохих дэмжлэгийг үзүүлэх, улмаар хууль эрх зүйн баримт бичгүүдэд үнэлгээ хийх зэрэг чиглэлээр Монгол Улсын засгийн газарт НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлсэн.

Хүүхэд хамгаалал

Хүүхэд хамгааллын үндэстний механизмыг бэхжүүлэх зорилгоор бодлого, хөтөлбөр боловсруулагчдыг хамруулан салбар хоорондын зохицуулалтыг сайжруулах, нийгмийн үйлчилгээний тэргүүн шугамд ажиллагчдын тохиолдлын удирдлагын чадавхыг бэхжүүлэх, цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх зэрэг чиглэлээр НҮБ-аас Монгол Улсын засгийн газарт дэмжлэг үзүүлж байна. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн нөхцөл байдлын шинжилгээ хийж, зөвлөмж гаргасны мөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газар боловсруулсан. Түүнчлэн цахим орчин дахь хүүхдийн бэлгийн хүчирхийллийг өдөөсөн материал нийтлэлийг хязгаарлах чиглэлээр үндэстний болон олон улсын хөгжлийн байгууллагууд, хувийн хэвшлийнхэн оролцсон олон талт хамтын ажиллагааны санаачилгууд идэвхтэй өрнөж эхэлсэн. Хурдан морь унаач хүүхдүүдийг хамгаалах асуудлаар ч олон нийтэд хандаж НҮБ-аас мэдэгдэл гаргаад байна.

Хүүхдийн эрхийн талаарх өсвөр насныхны мэдлэгийг сайжруулах


НҮБ-аас 2017 онд өргөн хүрээний нөлөөлөл сурталчилгааны үйл ажиллагаа явуулсны үр дүнд, ерөнхий боловсролын сургуулийн албан сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийн хичээлийг оруулах шийдвэрийг Монгол Улсын Эрүүл мэндийн болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд нар гаргасан билээ. Эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөр, агуулгад бэлгийн цогц боловсролын (БЦБ/CSE) агуулга тусгагдсан бөгөөд тус хичээлийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын 4-12-р ангийн сурагчдад бие даасан хичээл болгон оруулж байна. Түүнчлэн, 2019 онд НҮБ-аас баталсан Бэлгийн боловсролын олон улсын арга зүйн удирдамж (ITGSE)-ийг монгол хэлнээ орчуулан тус орны онцлог нөхцөл байдалд нийцүүлэн ашиглаж эхэлсний зэрэгцээ сургагч багш нарыг бэлтгэж зургаан хэсгээс бүрдсэн агуулгатай БЦБ хичээлд 2019 онд улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 4-12 дугаар ангийн нийт 377,932 сурагч хамрагдсан байна.

Төрийн албыг бэхжүүлэх


Монгол Улсад мэргэжлийн бөгөөд иргэн төвтэй төрийн албыг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаагаараа дамжуулан ядуу, эмзэг бүлгийн хүн амын хууль эрх зүйн хамгаалалтыг хангахын тулд НҮБ-аас төрийн албаны хариуцлагыг бэхжүүлэхэд чиглэсэн олон алхам хийсэн. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад иргэд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, нөлөөллийг хянах шинэ механизмыг нэвтрүүлсэн. Түүнчлэн мэргэжлийн бөгөөд иргэн төвтэй төрийн үйлчилгээ үзүүлэх ур чадвар, чадавхыг төрийн албан хаагчдад эзэмшүүлэх зорилгоор нийт төрийн албан хаагчдад зориулан явуулдаг сургалтын хэвшсэн механизмд шинэчлэл хийх, улмаар хөгжүүлэхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн. НҮБ нь үүрэг хүлээгчдийн чадавхыг дээшлүүлэх замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, олон нийтэд чанартай үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны горим стандарт, заавар удирдамж, холбогдох бусад баримт бичгүүдийг боловсруулах чиглэлээр засгийн газрын холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан.

ЗОРИЛГО 3.1:


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД:

Монгол Улсын Их хурал, ХЗДХЯ, ХНХЯ, ЭМЯ, Төрийн албан зөвлөл, ҮСХ, Хүний эрхийн үндэсний хороо, Жендэрийн үндэсний хороо, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Жендэрийн эрх тэгш байдлыг хамгаалах төв, Хүүхдийн биеийг үнэлэх, худалдаалахтай тэмцэх ТББ, Азийн сан, Монголын Банкны холбоо, АХБ

ЗОРИЛГО 3.2:



ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮД, ЗАЛУУЧУУДЫН (34 ХҮРТЭЛХ НАСНЫ) ТӨЛӨӨЛЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТУХАЙЛБАЛ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ, ЯАМДЫН САЙД, ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ИРГЭДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТҮВШИНД

Эмэгтэйчүүдийн төлөөлөл

Монгол Улсад мэргэжлийн бөгөөд иргэн төвтэй төрийн алба байгуулахад дэмжлэг үзүүлж төрийн албаны удирдах дээд албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд НҮБ-аас зохих хувь нэмрээ оруулж байна. НҮБ-аас Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх хэд хэдэн журмыг боловсруулах, батлуулах үйл явцад дэмжлэг үзүүлсэн. Ийнхүү НҮБ-ын зүгээс хүн бүрт, тэр дундаа эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхэнд төрийн албанд элсэх шалгалт өгөх, албан тушаал дэвших, Төрийн албаны зөвлөлийн удирдах албан тушаалд өрсөлдөх, Төрийн хяналтын зөвлөлд хандах зэрэг тэгш шударга, ээлтэй боломж нөхцөлийг бүрдүүлэх механизмыг бий болгоход чиглэсэн техникийн туслалцаа үзүүлж байна. Эдгээр журам нь төрийн захиргааны байгууллага дахь жендэрийн эрх тэгш байдлыг сайжруулах зорилготой. Түүнчлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл хамтарсан тогтоол гаргаж нийт төрийн албан хаагчдыг ажлын байран дахь дарамт шахалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх талаарх сургалтад нийт албан хаагчид заавал хамрагддаг байх журам тогтоохыг НҮБ-ын зүгээс дэмжихийн зэрэгцээ эмэгтэй төрийн албан хаагчдын ажлын байран дахь аюулгүй байдлыг хангах талаар олон алхмууд хийж байна. НҮБ нь Улсын их хурал дахь эмэгтэйчүүдийн төлөөлөлд квот тогтоохыг тууштай дэмжиж, нөлөөллийн ажиллагаа явуулсан нь өмнө нь хасагдах дөхөж байсан ч улс төрийн нам, эвслээс Улсын их хуралд нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь эмэгтэйчүүд байхаар Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусахад хувь нэмрээ оруулсан.

ЛГБТ (Лесби, Гей, Бисекс, Трансжендер) хүмүүст дэмжлэг үзүүлэх

Бэлгийн чиг хандлага, хүйсэд суурилсан хүчирхийлэл, аливаа ялгаварлан гадуурхалт, үзэн ядалтыг өдөөх нь гэмт хэрэг хэмээх Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг НҮБ-аас дэмжин ажиллаж байна. Тайлангийн хугацаанд “Чөлөөт, эрх тэгш Монгол Улс” (F&E) аяныг хоёрдох жилдээ НҮБ-аас үндэсний хэмжээнд зохион байгууллаа. “Бахархлын сар” арга хэмжээг Монгол Улс дахь НҮБ-ын системийн байгууллагууд дэмжин оролцож, арга хэмжээг нийгмийн сүлжээгээр түгээж олон нийтийн ойлголтыг

сайжруулахад түлхэц болсон. Энэ үеэр сургалтууд зохион байгуулагдсан бөгөөд Тэгш эрхийн төлөөх эвслийн бүлэгт дэмжлэг болж Иргэний нийгмийн байгууллагууд, соёлын төвүүд, ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалахыг дэмжиж байгаа элчин сайдын яамдын төлөөлөл оролцож сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, үйлчилгээ үзүүлээ.


Орон нутгийн иргэдийн хурлын хүчирхэг төлөөлөл

Тайлангийн хугацаанд орон нутгийн иргэдийн хурлын төлөөллийн байгууллагуудын чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Тухайлбал, аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдон ажиллаж буй 2000 гаруй эмэгтэйчүүдийг Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтанд хамруулан эрх мэдэлжүүлж, тэдэнд улс төрийн шийдвэр гаргахад илүү үр дүнтэй оролцох боломжийг олгосон. Сургалтын явцад тэдний олон төрлийн үүсгэл санаачилгыг удирдан чиглүүлэх, үзэл санаа нэгтэй хэсэгтэйгээ хамтран лобби бүлэг байгуулах, нутгийн иргэдтэй эв зүйтэй хамтран ажиллах зэргээр орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх ур чадвар, өөртөө итгэх итгэл нь сайжирсан. Эдгээр санаачилгын заримаас дурдвал, нийтийн аж ахуйн үйлчилгээний газруудын үйлчилгээнд хяналт тавих, төрийн байгууллагуудын шийдвэрийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор мэдээлэл солилцох уулзалтууд зохион байгуулах, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг орон нутгийн зөвлөлөөр батлуулахад чиглэсэн нөлөөлөл сурталчилгааны олон ажил хийсэн. Орон нутгийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн хурлын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд илүү итгэлтэй, нөлөөтэй болж байгаа талаар хөндлөнгийн үнэлгээний тайланд дүгнэсэн. Түүнчлэн Эмэгтэйчүүдийн манлайллын сургалт нь бүх шатны түвшинд эмэгтэйчүүд өөр хоорондоо холбоо сүлжээ үүсгэж ажиллахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа хэдий ч намчирхах хэлбэрээр бүлэглэн нэгдэх асуудал гарсан хэвээр байгааг анхаарах шаардлагатайг ч мөн тэмдэглэсэн байна.


Нийслэлийн гэр хорооллын дэд төвүүдийг хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулж, хүртээмжтэй, хариуцлагатай хотыг хөгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын захиргаанд НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлсэн. Үүний үр дүнд орон нутгийн засаг захиргааны шийдвэр гаргах, төлөвлөх, орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн иргэдийн оролцоог хангах зорилгоор хүн амынх нь 56.3 хувийг нь эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа найман хороо, хүн амынх нь 66.1 хувийг нь эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа нэг дэд төвд Орон нутгийн иргэдэд түшиглэсэн байгууллагыг байгуулсан. Энэ байгууллага нь эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тухайн дэд төвийн орон нутгийн бизнес эрхлэгчдийн онцлог хэрэгцээг шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж байна.

ЗОРИЛГО 3.2:


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД:

Монгол Улсын Их хурал, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн үндэстний хороо, АХБ

ЗОРИЛГО 3.3:



ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО, БАЙГУУЛЛАГУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ, ТЭДНИЙ САНАА БОДЛОО ЭРХ ТЭГШ ТҮНШИЙН ХУВЬД ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХИЙГ ДЭМЖИХ

Залуучуудын хөгжлийг дэмжих



Монгол Улсын түүхэнд анх удаа залуучуудын асуудлаар тусгайлан хууль батлагдсан нь чухал ач холбогдолтой болсон. Энэхүү Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг боловсруулж батлуулахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, залуучууд манлайлдаг ТББ-ууд,

УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо зэрэг байгууллагууд ихээхэн идэвх зүтгэл гаргаж ажилласан. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд хамтран улс орон даяар 21 аймаг, 9 дүүрэгт Залуучуудын хөгжлийн төв (ЗХТ/УДЦ)-үүд байгуулсан бөгөөд эдгээр Залуучуудын хөгжлийн төвд залуучуудыг эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн амьдрах ухааны сургалт, бэлгийн боловсрол болон нөхөн үржихүйн асуудлаар зөвлөгөө өгөх зэрэг олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж байна. Тайлангийн хугацаанд ЗХТ-үүдээр 15-34 насны 19,023 залуучууд үйлчлүүлсэн бөгөөд ялангуяа эмзэг бүлгийн буюу ажилгүй залуус, сургуулиас завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй залуус, гэртээ хүүхдээ хардаг залуу эхчүүдэд хандсан олон төрлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Залуучуудын оролцоог дэмжих платформ

НҮБ нь Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажиллаж улс төрчид хийгээд шийдвэр гаргагчдад чиглүүлэн залуучуудын өмнө тулгамдаж байгаа шийдвэрлэвэл зохих асуудлуудыг нэгдэн хэлэлцэх, санал санаачилга гаргах, зохион байгуулах, нөлөөлөл сурталчилгаа хийх зорилго агуулсан залуучуудын платформыг дэмжин идэвхжүүлж ажиллаа. Үүний нэг жишээ бол Залуучуудын хөгжлийн асуудлаарх үндэсний чуулганыг зохион байгуулсан нь залуучуудад болон залуучуудын иргэний нийгмийн байгууллагуудад тулгамдсан асуудлуудаа хэлэлцэх, үзэл бодлоо илэрхийлэх гол платформ нь болж өгсөн. Залуучуудын асуудлаарх мэдээлэл судалгаанд суурилсан бодлого, хөтөлбөр, залуучуудын



хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр 2016 онд ганцхан удаа үндэстний хэмжээний нөлөөлөл сурталчилгааны ажил/платформ хийгдэж байсан бол одоогийн байдлаар ийм төрлийн арга хэмжээг гурван удаа зохион байгуулсан байна.

ХЭҮК-оос гаргасан ЖДҮ-үүдэд хөдөлмөрлөх эрх хэрхэн хангагдаж байгаа талаарх тайланд эмэгтэйчүүд, залуучуудын хөдөлмөрлөх эрх ихээхэн зөрчигдөж байгаа болон Залуучуудын хөдөлмөрлөх эрхийн талаар нөлөөлөл сурталчилгаа хийх зорилгоор Зохистой хөдөлмөрийг дэмжих залуучуудын сүлжээ байгуулагдсан зэргийг онцлон тэмдэглэсэн. Ажил олгогчид олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын гол нөхцөл болсон хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр эрхлэлтийг устгах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, ялгаварлан гадуурхалгүй байх зэрэг хөдөлмөрийн эрхийн асуудлаар аж ахуйн нэгжүүд чанд мөрдөж ажиллах хяналтын хуудсыг боловсруулсан. Зохистой хөдөлмөрийг дэмжих залуучуудын сүлжээ нь залуучуудын дунд хөдөлмөрийн хүрээн дэх суурь зарчим болон хөдөлмөрлөх эрхийг сурталчлах зорилгоор НҮБ-ын дэмжлэгтэйгээр байгуулагдсан.

Өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах


Тайлангийн хугацаанд Завхан, Говь-Алтай, Өмнөговь зэрэг аймгуудад өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулах, амьдрах ухааныг хөгжүүлэх чиглэлээр төрөл бүрийн шинэлэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас үзүүлэх дэмжлэгээ үргэлжлүүлж байна. НҮБ нь үүрэг хүлээгчдийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж байгаагийн зэрэгцээ хэрэгжүүлж буй төслүүдийн үр өгөөжийг сайжруулахын тулд өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар мэдээлэл цуглуулах судалгаа хийлээ. 2018-2019 оны хичээлийн жилд эхэлсэн эрүүл мэндийн хичээлийг НҮБ-аас тууштай дэмжиж, багш сургагчдын ажлыг илүү үр дүнтэй болгоход чиглэсэн сургалтууд зохион байгуулах, хичээлийн удирдамж, агуулгыг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Залуучуудын өөрсдийн хөгжүүлсэн “Амьдрах ухаан/Lifehack” хэмээх гар утасны тоглоом, охидын сарын тэмдгийн эрүүл ахуйн чиглэлээр охидод туслах #Оки” гар утасны аппликейшн гэх зэрэг шинэлэг аргуудыг ашиглан бэлгийн боловсролын дижитал хэлбэрийн нөлөөлөл сурталчилгааг орон даяар туршиж байна.

Сайн дурын үйл ажиллагааг дэмжих


НҮБ нь Дэлхийн сайн дурын байгууллагын дэмжлэгтэйгээр Монгол Улсад сайн дурын үйл ажиллагааг өрнүүлэн хөгжүүлж ирсэн. Сайн дурынханд болон сайн дурынхныг оролцуулах үйл ажиллагаа хариуцсан төрийн албаныханд зориулсан шинэ загваруудыг ч боловсруулаад байна. Эдгээр загваруудыг сайн дурын ажилтнуудыг хамруулсан үндэстний сургалтуудад ашиглаж байгаа бөгөөд эдгээр арга хэмжээнд ЗХТ-үүдийн ажилтнууд, мэргэжилтнүүдийг хамруулсан болно. Баянхонгор аймаг, Баянзүрх дүүрэгт 11-р сараас хэрэгжүүлж эхэлсэн Цэвэр агаар төслүүдэд ажиллах сайн дурын ажилтан залуучуудыг сонгох шалгаруулалт, сургалтад 590 сайн дурын ажилтан хамрагдсан.

ЗОРИЛГО 3.3:


ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ:



НИЙТ БОСГОСОН ХӨРӨНГӨ, САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР



НУБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЦУУЛАЛТ 2017-2019



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУД:

Монгол Улсын Их хурал, ХНХЯ, БСШУСЯ, ЭМЯ, Орон нутгийн захиргаад, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэр бүл, хүүхэд, залууудын хөгжлийн газар, Иргэний боловсролын төв, Монголын эмэгтэйчүүдийн үндэсний сүлжээ

■ МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА

Монгол Улс дахь НҮБ нь Мэдээлэл харилцааны багаараа дамжуулан ТХЗ-ын талаарх мэдлэг мэдээллийг түгээн дэлгэрүүлэх хийгээд агаарын бохирдолтой тэмцэх, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны асуудлууд, жендэрийн эрх тэгш байдал, жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн хамгаалал, боловсрол, хариуцлагатай үйлдвэрлэл хэрэглээ, төрийн албаны шинэчлэл, залуучуудын бизнес эрхлэлт гэх мэт хөгжлийн олон асуудлаар нөлөөлөл сурталчилгааны ажлыг хийж байна.

НҮБ-ын системийн байгууллагууд нь ТХЗ-ын талаарх ойлголтыг өргөжүүлэн дэлгэрүүлэх зорилгоор нөлөөлөл сурталчилгааны компант ажлыг хамтран зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд, оюутнууд, ахмад настнууд, нийгмийн эмзэг бүлгийнхний төлөөллийг оролцуулж олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааны зохион байгуулалтдаа өөрчлөлт хийсэн.

ТХЗ-ыг сурталчилсан энэхүү компанит ажлын хүрээнд хэвлэл мэдээллийн хэд хэдэн бүтээгдэхүүнийг нийтлэн түгээж, ТХЗ-ын нөлөөлөл сурталчилгааны арга хэмжээг олон хэлбэрээр зохион байгуулсан. Энэ нь Монгол Улсад НҮБ-ын өдрийг бүхэл өдөржин нээлттэйгээр тэмдэглэсэн анхны компанит ажил болсон бөгөөд үүнд #ActNow #SDGsTaLx хэмээх шинэлэг агуулгын дор олон түмэнд танигдсан нийгмийн болон эко-идэвхтнүүд, зураачид, зохиолчид, соён гэгээрүүлэгчид, төрийн албан хаагчид, жүжигчид, гарааны ногоон бизнес эрхлэгчид өргөнөөр оролцсон төдийгүй тогтвортой хөгжилд хүрэх өөрсдийн хүсэл тэмүүллийг илэрхийлсэн 10 минутын урам зориг өгсөн агуулгатай ишлэлүүд багтаасан видео бичлэг үзүүлж, НҮБ-ын нээлттэй хаалганы өдөрлөгийн үйл ажиллагаагаар өндөрлөсөн билээ. Энэ арга хэмжээнд Монгол Улсын шилдэг одууд, дуучид, хөгжмийн хамтлагууд оролцсоны зэрэгцээ 500 гаруй зочид НҮБ-ын нээлттэй өдөрлөгт хүрэлцэн ирж, арга хэмжээний талаарх мэдээлэл гуч гаруй мянган хүнд нийгмийн сүлжээгээр дамжин хүрч, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд түгээн дамжуулсан. НҮБ-ын нээлттэй хаалганы өдөрлөгт бага насны хүүхдүүд, ахмад настан, оюутнууд, мэргэжлийн хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зочилсон. ТХЗ-ын талаарх ойлголт мэдлэгийг түгээх зорилго агуулсан энэхүү компанит ажлыг 12-р сард тохиосон НҮБ-ын 75 жилийн ойд зориулсан Хэлэлцүүлгээр дүгнэн хааж, НҮБ-ын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд мэдээлсэн.

Хүний эрхийн өдөр, Дэлхийн хүнсний өдөр, Дэлхийн чихрийн шижинтэй тэмцэх өдөр, Дэлхийн эрүүл мэндийн өдөр, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах өдөр, Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр, НҮБ-ын өдөр, ДОХ-той тэмцэх өдөр, Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн идэвхжил гэх зэрэг Дэлхийн болон НҮБ-ын тэмдэглэлт өдрүүдийг хүндэтгэн өнгөрүүлж, энэ өдрүүдэд зориулан гарсан гол уриа, мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэж ирсэн.

Түүнчлэн НҮБ-ын ажилтнууд, НҮБ-ын Суурин зохицуулагч, НҮБ-ын системийн байгууллагын удирдлагууд таван их сургуулийн 500 гаруй оюутан, ерөнхий боловсролын 23 сургуулийн 1000 гаруй сурагчдыг хамруулсан арга хэмжээнд оролцож ТХЗ-ын талаарх ойлголт, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх лекц, яриа, хэлэлцүүлэгт оролцсон. Түүнчлэн НҮБ-ын ажилтнууд Улаанбаатар хотын Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 200 мод тарьж агаарын бохирдлыг бууруулахад өөрсдийн хувь нэмрийг оруулах арга хэмжээг үлгэрлэлээ.

■ НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

НҮБ-ын Үйл ажиллагааны удирдлагын баг (ОМТ) нь Монгол Улс дахь НҮБ-ын нийтлэг үйл ажиллагаа, үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага хоорондын харилцааны механизм юм. НҮБ-ын Үйл ажиллагааны удирдлагын баг нь НҮБ-аас хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаа үр ашигтай байх, үйл ажиллагааны зардлыг үр ашигтай зарцуулахад анхаарч ажилладаг юм. НҮБ-ын системийн байгууллагуудын идэвхтэй хамтын ажиллагаа, дэмжлэгт суурилан 2019 онд урт хугацаатай нийтлэг үйлчилгээний хамтарсан гэрээ (LTA) байгуулах, ногоон орчинг бүрдүүлэх, хог хаягдлын менежментийн үйл ажиллагаа, НҮБ-ын ажлын байр, орчныг тохижуулах зэргээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулахыг зорьж байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан зэрэг байгууллагууд нь албан хэрэгцээний автомашиныг дундаа хамтран ашиглах төслийг 2017 оноос хойш үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр, гуравдагч талын үйлчилгээ шаардлагагүй болж үйл ажиллагааны зардлыг бууруулахад сайнаар нөлөөлж байгаагийн зэрэгцээ автомашины парк ашиглалт, нүүрстөрөгчийн ул мөрийг багасгах, өртөг зардал хэмнэх, ажилтнууд болон тээврийн хэрэгслийн аюулгүй, баталгаатай байдлыг сайжруулахад эерэгээр нөлөөлсөн.

Монгол Улс дахь НҮБ нь бизнесийн үйл ажиллагаагаа оновчтой болгох, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд НҮБ-ын тогтолцоог шинэчлэн өөрчлөх, ялангуяа, бизнесийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Ерөнхий нарийн бичгийн даргаас дэвшүүлсэн Бизнесийн инновацийн бүлэг (BIG)-ийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх шинэчлэлийн зорилгыг дэмжиж байгаа болно. 2019–2023 онуудад хэрэгжүүлэх Бизнесийн үйл ажиллагааны стратеги (БҮАС/ВOS) нь өнөөгийн хэрэгжүүлж байгаа НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ (UNDAF) болон түүний мөрөөр хэрэгжүүлэх санал санаачилгуудтай нийцэж байгаа бөгөөд бизнесийн үйл ажиллагааг илүү оновчтой, стратегитай, уялдаа холбоотой, үр ашигтай явуулах замаар хариуцлагатай, ил тод байдлыг хангах зорилго тавьж байна.

Бизнесийн үйл ажиллагааны стратеги (БҮАС)-ийг дараах зарчим, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- Бизнесийн үйл ажиллагаа нь НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх стратегийн чухал хэрэгсэл болно. Бизнесийн үйл ажиллагааны стратеги (БҮАС) нь Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ (ХТХ/UNDAF)-г хэрэгжүүлэх стратегийн болон үр ашигтай төлөвлөгөө болохын зэрэгцээ бизнесийн үйл ажиллагааг хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагатай уялдуулах, НҮБ-ын системийн нийт байгууллагуудын хөрөнгө нөөц, үйл ажиллагааны чадавх, туршлага, үр ашгийг дээшлүүлэх нөхцөлийг хангана. БҮАС нь зардлын хяналт шинжилгээг сайжруулах, хүлээгдэж буй үр дүнгийн гүйцэтгэлд хяналт тавих, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг тогтмол гаргах зэргээр үр дүнгийн ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлнэ.
- Оновчтой байдал, уялдаа холбоо. Давхардмал бүтэц, үйл ажиллагааг аль болох арилгаж хөтөлбөрийн хэрэгжилт, шийдлийг бизнесийн үр ашгийг дээд хэмжээнд хүргэхэд чиглүүлэхийн зэрэгцээ байгууллагуудын давуу тал, туршлага, өнөөгийн байгаа хөрөнгө нөөц, тогтолцоо, сүлжээг ашиглах замаар Монгол Улсад хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийн хөрөнгө нөөцийн үргүй зарцуулалтыг хязгаарлана.

- НҮБ-ын системийн байгууллагууд нь ажил үүргээ өөр хоорондоо хуваарилах замаар хүлээх үүрэг, хариуцлага харилцан хуваалцаж нийт байгууллагуудын оролцоог хангаж, бусад байгууллагуудынхаа тогтсон систем, дүрэм журам, давуу тал, түүний дотор дэлхийн болоод бүс нутгийн мэргэшсэн төвүүдийн хүчийг үр дүнтэй ашиглахын зэрэгцээ, НҮБ-ын БҮАС-ийн зорилгыг хэрэгжүүлэх, ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйл явцыг дэмжихэд чиглүүлж НҮБ-ын Үйл ажиллагааны удирдлагын баг (ОМТ)-ийн мэдлэг, чадавхыг дээшлүүлнэ.
- Үр нөлөө, нарийн төвөгтэй эсэхэд нь тулгуурлан үйл ажиллагааг удирдах арга зам, хөтөлбөрийн үйл ажиллагааны эрэмбийг тогтоож, шинжилгээ судалгааны арга хэрэгсэл БҮАС-ийн заавар удирдамжийг ашиглан нарийн төвөгтэй ч өндөр үр нөлөө бүхий цөөн тооны арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулна. Ингэхдээ гол зардлууд, өндөр үр ашиг, төлбөрийн гүйлгээний тоо хэмжээ, хэрэгжүүлэх арга зам нь хэт төвөгтэй биш байх, бизнесийн шийдлийг нь цаашид өргөжүүлж болох эсэх зэрэгт нь анхаарна.
- Тухайн байгууллагын мандат, хамтын зорилгын аль алиныг хэрэгжүүлэх зорилт тавьж үйл ажиллагааны тогтсон дүрэм журмаас гадна шинэлэг боломжуудыг хайж олох, үр дүнтэй хамтын ажиллагааны шинэлэг арга замыг олж НҮБ-ын өмнө тавигдаж буй босоо болон хэвтээ хариуцлагын тогтолцооны асуудлыг шийдвэрлэнэ хэмээн найдаж байна. Улмаар БҮАС-ийг ашиглан хүлээж буй үр дүндээ нийцүүлэн боломж нөхцөлийг эрэлхийлж, зохион байгуулалтаа шинэчилж, хүч чадавхаа нэгтгэн нийцүүлж, хөрөнгө нөөцийг үр ашигтай зарцуулж ажиллана.

ХАВСРАЛТ: НИЙТ ТӨСВИЙН ХҮРЭЭ												
Байгууллага	НҮБ-ын ХТХ НИЙТ ТӨСӨВ	Нийт шаардагдах			Нийт босгосон			Нэмж босгох	ЗАРЦУЛАЛТ			
		Бүгд	Core	Non-Core	Бүгд	Core	Non-Core		2017	2018	2019	Бүгд
НИЙТ ДҮН	79,670,034	118,187,910	25,795,522	92,392,388	113,649,994	25,795,522	87,854,472	4,537,916	21,090,635	22,139,787	23,259,146	66,489,567
Үр дүн 1 Бүгд	34,199,242	64,409,255	12,708,299	51,700,955	61,249,097	12,708,299	48,540,798	3,160,157	10,454,465	11,690,580	10,429,698	32,574,742
ХХААБ	3,700,000	9,074,096	1,977,242	7,096,854	9,074,096	1,977,242	7,096,854	-	4,352,692	1,601,234	938,487	6,892,413
ОАЭА	1,400,000	300,435		300,435	250,991		250,991	49,445	0	66,452	74,326	140,778
ОУХБ	750,000	1,501,600	1,381,600	120,000	1,451,600	1,381,600	70,000	50,000	434,962	181,428	255,335	871,725
ОУШХБ		3,252,455	1,875,000	1,377,455	3,252,455	1,875,000	1,377,455	-	400,224	691,090	506,871	1,598,184
НҮБ-Нутагшилт	100,000	4,681,467	-	4,681,467	4,681,467	-	4,681,467	-	95,167	86,300	985,662	1,167,129
НҮБ ХХ	20,000,000	19,332,829	2,326,357	17,006,472	19,196,058	2,326,357	16,869,701	136,771	3,886,805	2,879,921	2,485,021	9,251,747
НҮБ БОХ	1,500,000	4,033,799		4,033,799	1,544,461		1,544,461	2,489,338	313,863	371,200	511,637	1,196,700
НҮБ БШУСБ	322,000	278,000	95,000	183,000	203,000	95,000	108,000	75,000	0	52,000	75,000	127,000
НҮБ ХС	100,000	6,048,541	2,925,159	3,123,382	5,816,444	2,925,159	2,891,286	232,097	220,752	604,177	1,365,224	2,190,153
НҮБ АҮХБ	2,277,242	13,454,875		13,454,875	13,454,875		13,454,875	-	750,000	5,156,778	908,485	6,815,263
ДХХ		323,215		323,215	195,708		195,708	127,507	0	0	195,708	195,708
ДЭМБ	4,050,000	2,127,942	2,127,942	-	2,127,942	2,127,942	-	-	0	0	2,127,942	2,127,942
Үр дүн 2 Бүгд	37,855,792	32,152,782	7,929,813	24,222,969	31,052,692	7,929,813	23,122,880	1,100,089	6,123,160	6,358,828	8,004,889	20,486,876
ХХААБ		1,220,223	820,275	399,948	1,220,223	820,275	399,948	-	164,572	148,675	235,466	548,713
ОАЭБ	1,700,000	1,374,767		1,374,767	1,267,744		1,267,744	107,023	6,376	748,421	386,354	1,141,151
ОУХБ	750,000	19,000	19,000	-	19,000	19,000	-	-	17,815.00	1,196.00	0.00	19,011
ОУШХБ		1,090,104	0	1,090,104	1,090,104	0	1,090,104	-	0.00	0.00	54,454.30	54,454
НҮБ-Нутагшилт	100,000	190,440		190,440	190,440		190,440	-	100,000	90,440	0	190,440
НҮБ ДОХ-ын сан		24,232	24,232	-	24,232	24,232	-	-	24,232	0	0	24,232
НҮБ БШУСБ	300,000	420,000	340,000	80,000	340,000	340,000	-	80,000	110,000	180,000	340,000	630,000
НҮБ ХАС	9,300,000	5,030,296	911,303	4,118,993	5,030,296	911,303	4,118,993	-	931,283	1,705,872	2,255,182	4,892,337
НҮБ ХС	18,513,227	16,798,521	713,367	16,085,155	15,903,455	713,367	15,190,088	895,066	1,850,282	1,855,625	3,325,432	7,031,339
ДЭМБ	7,192,565	5,985,199	5,101,636	883,563	5,967,199	5,101,636	865,563	18,000	2,918,600	1,628,599	1,408,000	5,955,199
Үр дүн 3 Бүгд	7,615,000	21,625,873	5,157,410	16,468,464	21,348,204	5,157,410	16,190,794	277,670	4,513,011	4,090,379	4,824,560	13,427,949
ОУХБ	1,000,000	1,066,641	442,900	623,741	1,066,641	442,900	623,741	-	340,678.00	89,322.00	151,041.00	581,041
ОУШХБ		1,762,573	0	1,762,573	1,762,573	0	1,762,573	-	189,579.20	139,965.20	2,100.00	331,644
НҮБ-Нутагшилт		148,320	0	148,320	148,320	0	148,320	-	48,320.00	100,000.00	0.00	148,320
НҮБ ХХ	750,000	8,650,000	600,000	8,050,000	8,650,000	600,000	8,050,000	-	1,029,522.53	1,693,085.00	2,058,514.52	4,781,122
НҮБ БШУСБ	365,000	-	0.00	-	0	0.00	-	-	0.00	0.00	0.00	0
НҮБ ХАС	5,000,000	7,179,504	3,463,588	3,715,916	7,179,504	3,463,588	3,715,916	-	2,562,949.92	1,645,921.84	2,106,614.00	6,315,486
НҮБ ХС	450,000	2,766,745	622,091	2,144,653	2,512,335	622,091	1,890,244	254,410	333,701.00	418,605.00	468,030.00	1,220,336
ДЭМБ	50,000	52,090	28,830	23,260	28,830	28,830	-	23,260	8,260.00	3,480.00	38,260.00	50,000

ХОЛБОО БАРИХ ХҮМҮҮС

Ерөнхий мэдээлэл **Төмөрсүхийн Алтансүвд**, НҮБ-ын Суурин зохицуулагчийн албаны мэргэжилтэн @ altansuvd.tumursukh@un.org

Үр дүнгийн чиглэл 1: **Элейн Конкиевич**, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч @ elaine.conkievich@undp.org

Үр дүн 1: **Өлзийхүүгийн Буяндэлгэр**, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн @ buyandelger.ulziikhuu@undp.org

Үр дүнгийн чиглэл 2: **Алекс Хейкенс**, НҮБ-ын Хүүхдийн сангийн Суурин төлөөлөгч @ aheikens@unicef.org

Үр дүн 2: **Дашдоржийн Хүрэлмаа**, НҮБ-ын Хүүхдийн сангийн Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн @ kdashdorj@unicef.org

Үр дүнгийн чиглэл 3: **Каори Ишикава**, НҮБ-ын Хүн амын сангийн Тэргүүн @ kishikawa@unfpa.org

Үр дүн 3: **Азейн Илиза**, НҮБ-ын Хүн амын сангийн Шадар суурин төлөөлөгч @ azyei@unfpa.org

